



МОНГОЛ УЛСЫН
АВЛИГААЙ ТЭМЦЭХ ГАЗАР

МЭДҮҮЛЭГ, МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР ГАРГАХ
НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНУУДАД ЗОРИУЛСАН

ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР ХОТ
2025 он



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нийтийн албан
тушаалтнуудад зориулсан

ГАРЫН АВЛАГА

(Шинэчилсэн 7 дахь хэвлэл)

УЛААНБААТАР ХОТ
2025 он

DDC
340'015
Э-81

Албан хэрэгцээнд зориулав.

©2025

Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нийтийн албан тушаалтнуудад зориулсан ГАРЫН АВЛАГА

Боловсруулсан:

Ц.БААСАНДЭЛГЭР АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар

Хянасан:

М.ДАВААТОГТОХ АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар

Б.БАЯРСАЙХАН АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга, ахлах комиссар

Манай хаяг:

14250 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж - 41, Монгол улс, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

Харилцах утас:

70112489, 70110252

Хэвлэсэн тоо: 15000 ширхэг

Хэвлэлийн хуудасны тоо: 12.5хх

Хэвлэсэн газар: "Урангар Пресс" ХХК

Эх бэлтгэсэн: Б.Тамир

**АГУУЛГА**

Удиртгал.....4

Хууль тогтоомж

Монгол Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоол5

Монгол Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 01 дүгээр тогтоол 7

- Нэгдүгээр хавсралт: “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүртгэх, хянах, хадгалах журам”9

- Аравдугаар хавсралт: “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”17

Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын маягт бөглөх заавар

- ХАСХОМ-ийн тухай21

- ХАСУМ-ийн тухай44

- Мэдэгдэл, тайлбарын тухай.....55



УДИРТГАЛ

Энэхүү гарын авлагыг Авлигын эсрэг хууль тогтоомж болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 1.6-д заасныг үндэслэн боловсруулсан болно.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд нь Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг, нийтийн албан тушаалтан нь Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон Хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ээ үнэн зөв мэдүүлэхээс гадна Ашиг сонирхлын мэдэгдэл, тайлбар (Мэдэгдэл, тайлбар)-ыг гаргах үүрэг хүлээдэг. Албан тушаалтнаас уг үүргийнхээ хэрэгжилтийг хангахад нь дэмжлэг болох зорилгоор мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын маягтын талбар дахь нэр томьёоны тодорхойлолтыг түгээмэл гардаг асуултад хариулсан байдлаар зааврыг гарын авлагад тусгав.

Санал, хүсэлт

Энэхүү гарын авлагыг Авлигатай тэмцэх газраас тухай бүр боловсронгуй болгоход анхаарч ажиллах бөгөөд үүнтэй холбоотой аливаа залруулга, санал, хүсэлтийг тус газрын contact@jaac.mn хаягаар ирүүлнэ үү.

Нэмэлт асуулт

Хэрэв Та хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мөн ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар гаргах явцад энэхүү гарын авлагад тодорхой тусгаадаагүй асуудалтай холбоотой нэмэлт асуулт гарвал өөрийн харьяа байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хадгалах Эрх Бүхий Албан Тушаалтан (ЭБАТ)-д хандана үү.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 02-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, Авлигын эсрэг хуулийн 10.1, 10.7, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.1, 23.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг Нэгдүгээр, “Мэдүүлэг гаргагчийн ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг Хоёрдугаар, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт”-ыг Гуравдугаар, “Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт”-ыг Дөрөвдүгээр, “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг Тавдугаар, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”-ыг Зургадугаар, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”-ыг Долдугаар, “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”-ыг Наймдугаар, “Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны баталгааны маягт”-ыг Есдүгээр, “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ыг Аравдугаар хавсралтаар тус тус баталсугай. (Энэ тогтоолын 2 дугаар хавсралтын 1.1 дэх хэсэг болон 10 дугаар хавсралтын 1.10 дахь заалт, 1.4.7, 1.4.10, 1.4.13 дахь дэд заалтад Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон.)

2. Журмыг үйл ажиллагаанд нэг мөр ойлгож хэрэглэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар ханган ажиллах, журмын



биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж байхыг Авлигатай тэмцэх газар (Тэргүүн комиссар З.Дашдаваа)-т даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 05 дугаар тогтоол, 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах болон хавсралтыг шинэчлэн батлах тухай” 20 дугаар тогтоол, 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Албан тушаалтын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай” 01 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын аравдугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5. Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

(Энэ тогтоолын 2 дугаар хавсралтын 1.1 дэх хэсэг болон 10 дугаар хавсралтын 1.10 дахь заалт, 1.4.7, 1.4.10, 1.4.13 дахь дэд заалтад Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон.)



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 01 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ын 1.10 дахь заалтын “алба” гэсний дараа “төлөөлөгчийн газар” гэж, “банкны эрх хүлээн авагч,” гэсний дараа “бүрэн эрхт төлөөлөгч, тусгай төлөөлөгч, мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүн,” гэж тус тус нэмсүгэй.

2. Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ын 1.10 дахь заалтын “өр барагдуулах” гэснийг “авлага барагдуулах” гэж, 1.4 дэх заалтын 1.4.7 дахь дэд заалтын “ТТ-1”-“ТТ-7”-д” гэснийг “ТТ-1”-“ТТ-8”-д” гэж, 1.4.10 дахь дэд заалтын “ТТ-1”-“ТТ7”-д” гэснийг “ТТ-1”-“ТТ-6”-д” гэж, 1.4.13 дахь дэд заалтын “ТТ-11”-“ТТ-19”-д” гэснийг “ТТТ-1”-“ТТТ-8”-д хамаарах албан тушаалтан болон тусгай техникийн үзлэгийн ажилтан, нягтлан бодогч” гэж, мөн 2 дугаар хавсралтын “Иргэншил” гэснийг “Иргэний харьяалал” гэж тус тус өөрчилсүгэй.



3. Албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолт хэвээр байгаа боловч ангилал, зэрэглэл нь өөрчлөгдсөн бол Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах" 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт заасныг баримтлан ажиллана.

4. Жагсаалтад орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох байгууллагад хүргүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар ханган, биелэлтийг жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж танилцуулахыг Авлигатай тэмцэх газар /Тэргүүн комиссар З.Дашдаваа/-т даалгасугай.

5. Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР



*Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2024 оны 04 дүгээр
сарын 02-ны өдрийн 05 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт*

ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ, МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАРЫГ БҮРТГЭХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу нийтийн албан тушаалтнаас өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээл, хувийн ашиг сонирхлын байдлыг болон нийтийн албанд томилогдоход хувийн ашиг сонирхол үүсэх эсэхийг хянуулахаар гаргасан, сонгуульд нэр дэвшиж байгаа этгээдээс гаргасан хөрөнгө орлого, зээлийн талаарх мэдээллийг бүртгэх, хянан шалгах, хадгалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журамд заасан нэр томъёог дараах утгаар ойлгоно.

1.2.1. “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг” (цаашид “ХАСХОМ” гэх) гэж мэдүүлэг гаргагчаас хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хувийн ашиг сонирхол, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийн талаар гаргасан мэдээллийг.

1.2.2. “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг” (цаашид “ХАСУМ” гэх) гэж нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдээс томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар дамжуулан Авлигатай тэмцэх газарт мэдүүлж байгаа тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг хянуулахаар гаргасан мэдээллийг.

1.2.3. “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг” (цаашид “Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ” гэх) гэж Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Монгол Улсын Их Хурлын сонгууль, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшиж байгаа иргэнээс эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өөрийн болон гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлого, зээлийн талаар гаргасан мэдээллийг.

1.2.4. “Баталгааны маягт” гэж энэ зүйлийн 1.2.1, 1.2.2, 1.2.3-т заасан ХАСХОМ, ХАСУМ, Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааг.



1.2.5. “Мэдэгдэл” гэж нийтийн албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргасан мэдээллийг.

1.2.6. “Тайлбар” гэж нийтийн албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд энэ тухай батлагдсан маягтын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргасан мэдээллийг.

1.2.7. “Мэдүүлэг” гэдэгт энэ зүйлийн 1.2.1, 1.2.2, 1.2.3-т заасан ХАСХОМ, ХАСУМ, Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг.

1.2.8. “Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан” (цаашид “ЭБАТ” гэх) гэж тухайн байгууллагын захиргаа, хуулийн асуудал эрхэлсэн албан тушаалыг эрхлэхийн зэрэгцээ байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч, бүртгэх, хадгалах болон хуульд заасан бусад чиг үүргийг хавсран гүйцэтгэхээр томилогдсон албан хаагч, ажилтныг.

1.3. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг Авлигатай тэмцэх газраас хөтлөх Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем (<https://meduuleg.iaac.mn/>)-ээр гаргах бөгөөд мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягыг хэвлэмэл байдлаар тухайн байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгнө.

1.4. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжоор зохион байгуулалтын бүтэц, орон тоо, хүний нөөцийн мэдээллийг нь төрийн нууцад хамааруулсан байгууллагын албан тушаалтан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбараа хэвлэмэл байдлаар гаргаж болно.

1.5. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргасан хугацааг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд баталгаажуулсан (хэвлэмэл байдлаар гаргасан бол ЭБАТ-д бүртгүүлсэн) он, сар, өдрөөр тооцно.

1.6. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх журам, мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч бүртгэх бүртгэлийн болон мэдээ, тайлангийн маягт, мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах зааврыг Авлигатай тэмцэх газрын дарга батална.

1.7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн ХОМ гаргавал зохих этгээдийн бүртгэл, лавлагааны маягыг Авлигатай тэмцэх газрын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга хамтран батална.

1.8. Авлигатай тэмцэх газар Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг бүртгэж, хүлээн авсан тухай лавлагаа /тодорхойлолт/-г холбогдох хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.



Хоёр. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах харьяалал

2.1. Мэдүүлэг гаргагч дараах байгууллага, албан тушаалтанд мэдүүлгээ гаргаж бүртгүүлнэ.

2.1.1. Төрийн өндөр, түүнтэй зэрэг зиндаа адилтгах албан тушаалтан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигатай тэмцэх газарт.

2.1.2. Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог зөвлөл, хорооны орон тооны гишүүн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх тухайн байгууллагын Ажлын албанд.

2.1.3. Энэхүү журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Улсын Их Хурлаас томилдог албан тушаалтан Улсын Их Хурлын Тамгын газарт, Ерөнхийлөгчийн томилдог албан тушаалтан Ерөнхийлөгчийн Тамгын газарт, Засгийн газраас томилдог албан тушаалтан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

2.1.4. Бүх шатны шүүхийн шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлд.

2.1.5. Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд.

2.1.6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Ажлын албаны ажилтан, бүх шатны Засаг дарга, Засаг даргын орлогч тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд.

2.1.7. Бүх шатны Засаг даргаас томилогддог албан тушаалтан тухайн шатны Засаг даргын Тамгын газарт.

2.1.8. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар (аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар)-ын удирдах болон эрх бүхий албан тушаалтан түүнийг томилох албан тушаалтанд.

2.1.9. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын удирдах болон эрх бүхий албан тушаалтан нь түүнийг томилох эрх бүхий албан тушаалтанд.

2.1.10. Төрийн тодорхой чиг үүрэг, ажил үйлчилгээг холбогдох хууль, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг Засгийн газрын бус байгууллага (төрийн бус байгууллага), нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид.

2.1.11. Төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсаас гадаад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Засгийн газрын тусгай сангийн болон Засгийн газар хоорондын гэрээ, зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан тухайн төсвийн захирагчид.

2.1.12. Энэхүү журмын 2.1.1-2.1.11-д зааснаас бусад албан



тушаалтан түүнийг томилох эрх бүхий албан тушаалтанд.

2.2. Мэдэгдэл, тайлбарыг тухайн чиг үүргийг гүйцэтгүүлэхээр томилсон, эсхүл шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

2.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч тухайн шатны сонгуулийн хороонд гаргана.

2.4. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлнэ.

Гурав. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авах, бүртгэх
байгууллагын удирдлага, ЭБАТ-ын эрх, үүрэг

3.1. Байгууллагын удирдлага мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч, бүртгэх, тайлагнах, хадгалах хүрээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах.

3.1.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гүйцэтгэлийг хяналт тавих, тайлагнах.

3.1.3. Байгууллага, салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах, нийтийн албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч, бүртгэх, мэдэгдэл, тайлбарыг хянан шийдвэрлэх, энэ талаар арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх.

3.1.4. Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, энэ талаар тогтоосон журам, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөх.

3.1.5. Хүний хувийн мэдээллийг бусдад задруулах, задрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх.

3.1.6. Нийтийн албан тушаалтнаас гаргасан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын тайланг тогтоосон хугацаанд тайлагнах, тайлангийн үнэн зөвийг хариуцах.

3.1.7. Авлигатай тэмцэх газрын хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх, шаардлагатай баримт, мэдээ, мэдээллийг саадгүй гаргаж өгөх.

3.1.8. ЭБАТ-ыг тогтвор суурьшилтай ажиллуулах, томилох, чөлөөлөх тухай бүрд Авлигатай тэмцэх газарт албан ёсоор мэдэгдэх.

3.1.9. Тухайн байгууллагын ЭБАТ-ыг томилж, албан тушаалынх



нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд уг асуудлыг эрхлэх орон тооны ажилтантай байж болно.

3.1.10. ЭБАТ-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх.

3.1.11. Холбогдох бусад.

3.2. ЭБАТ дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.1. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд өөрийн эрхээр нэвтрэх, харьяа салбар, нэгжийн ЭБАТ-ын цахим системд эрхийг зохицуулах, цахим системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах.

3.2.2. Хүний хувийн мэдээллийг задрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аливаа хэлбэрээр задруулахгүй байх, мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх.

3.2.3. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд нийтийн албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нөхцөлийг бүрдүүлж, эрхийг үүсгэх, хяналт тавих.

3.2.4. Харьяа салбар, нэгжийн ЭБАТ-ын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөн туслах, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

3.2.5. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, баталгааны маягтад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөхийг шаардах.

3.2.6. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, мэдэгдэл, тайлбарын шийдвэрлэлт, байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх журмын дагуу мэдээлэл өгсөн тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан нийтийн албан тушаалтан бэлэг авах, давхар ажил эрхлэхтэй холбоотой бүртгэл хөтлөх, энэ тухай тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.

3.2.7. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын тайлан, мэдээний үнэн бодит байдлыг хариуцах.

3.2.8. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдүүлэг гаргагчийн шилжилт, хөдөлгөөнийг хөтлөх.

3.2.9. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, тайлан мэдээ, холбогдох бусад баримтыг зориулалтын байр, тавиур, шүүгээнд холбогдох журам, стандартын дагуу хадгалж, тухайн онд үүсэж хөтлөгдсөн баримтуудаар архивын нэгж үүсгэж, хуульд заасан хугацаанд архивд шилжүүлэх.

3.2.10. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авах, бүртгэх. Энэ чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээллээр хангагдах, сургалтад хамрагдах.

3.2.11. Тухайн жилийн мэдүүлгээ шинэчлэн гаргасан хугацаанаас хойш байгууллагын бүтцийн нэгж дотроо томилогдсон, сонгогдсон



мэдүүлэг гаргагчийн шилжилт, хөдөлгөөнийг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд хийх.

3.2.12. ЭБАТ тайлан, мэдээг дараах тогтоосон хугацаанд зохих журмын дагуу гаргана.

3.2.12.1. ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулах хугацаанаас өмнө мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.

3.2.12.2. Салбар, нэгжийн ЭБАТ мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч дууссанаас хойш тайлан, мэдээг 7 хоногийн дотор дээд шатны байгууллагад хүргүүлэх.

3.2.12.3. Дээд шатны байгууллагын ЭБАТ ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулснаас хойш 14 хоногийн дотор холбогдох хууль, журмын биелэлтийн талаарх тайланг, мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт харьяа салбар, нэгжийн түвшинд нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.

3.3. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, баталгааны маягтыг хүлээн авах, илгээх, бүртгэхэд төрийн албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, цахим гарын үсгийн тухай хууль тогтоомжийг баримтална.

Дөрөв. Мэдүүлэг гаргах, хянах, бүртгэх

4.1. ХАСХОМ, ХАСУМ, Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг тухайн этгээд Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системээр дамжуулан гаргаж, баталгааны маягтад гарын үсэг зурж энэ журмын 2.1, 2.3 дахь хэсэгт заасан байгууллага, ЭБАТ-д хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

4.2. ХАСХОМ, Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг өмнөх оны 12 дугаар сарын 31-ний байдлаар, ХАСУМ-ийг тухайн мэдүүлгийг гаргах үеийн нөхцөл байдлаар, хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол өөрчлөлт орсон үеийн байдлаар тус тус мэдүүлнэ.

4.3. ХАСУМ гаргах, хянах.

4.3.1. Мэдүүлэг гаргах нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд /шинээр болон туршилтын хугацаанд, сэлгэн, шилжин, хавсран, хослон, түр орлон гүйцэтгэх тухай бүр/ нь ийнхүү нэр дэвших бүрд ХАСУМ гаргана.

4.3.2. Аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал, хуулийн этгээдийн хэлбэр, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн боловч эрхлэх асуудлын чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт ороогүй, Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажлын байрыг хэвээр хадгалж байсан, шүүхийн шийдвэрээр урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоосон бол ХАСУМ гаргахгүй.

4.3.3. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан ХАСУМ-



ийг хүлээн авч зохих журмын дагуу албан бичгийн хамт Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

4.3.4. Авлигатай тэмцэх газар ХАСУМ-ийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан нэр дэвшигч тухайн албан тушаалыг эрхлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг мэдүүлгийн мэдээлэл, албан тушаалын тодорхойлолт, төрийн мэдээллийн нэгдсэн санд дахь мэдээлэлд үндэслэн хянах ба зайлшгүй шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримтыг нэр дэвшигч болон томилох эрх бүхий байгууллагаас гаргуулан хянаж, албан бичгээр хариу мэдэгдэнэ.

4.4. ХАСХОМ гаргах, бүртгэх

4.4.1. Мэдүүлэг гаргагч ХАСХОМ-ийг тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор шинээр, цаашид албан тушаалыг эрхэлж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргана.

4.4.2. Энэ журмын 4.4.1-д заасан хугацаанд мэдүүлэг гаргасны дараа хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол энэ тухай ийнхүү өөрчлөлт орсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор гаргана.

4.4.3. Тухайн жилийн мэдүүлгээ шинэчлэн гаргасан хугацаанаас хойш мэдүүлгээ гаргасан байгууллагын бүтцийн нэгж дотроо албан тушаалд томилогдсон бол ХАСХОМ-ийг 30 хоногийн дахин гаргахгүй байж болно.

4.4.4. ХАСХОМ-ийг энэ журмын 2.1 заасан байгууллагад бүртгэнэ.

4.5. Сонгуульд нэр дэвшигч ХОМ гаргах, бүртгэх

4.5.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигатай тэмцэх газарт, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн хороонд сонгуулийн хуульд заасан хугацаанд тус тус хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргана.

4.5.2. Авлигатай тэмцэх газар Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшсэн, мэдүүлэг гаргавал зохих этгээдийн нэрсийн жагсаалтад үндэслэн мэдүүлэг гаргах эрхийг тус газрын Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд үүсгэж, бүртгэнэ.

4.5.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч ХОМ-ээ тухайн шатны сонгуулийн хороонд бүртгүүлнэ.

Тав. Мэдэгдэл, тайлбар гаргах, шийдвэрлэх

5.1. Нийтийн албан тушаалтан тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан



үүрэг гүйцэтгэхээс татгалзаж мэдэгдэл, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд энэ тухай тайлбарыг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системээр дамжуулан гаргаж, баталгаажуулна.

5.2. Мэдэгдэл, тайлбарыг томилох эрх бүхий албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг даруй гаргаж, баталгаажуулах ба шийдвэрийг нийтийн албан тушаалтанд мэдэгдэж, маягтыг ЭБАТ-д хүлээлгэн өгч, цахим системд бүртгүүлнэ.

5.3. Нийтийн албан тушаалтан Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүйгээр олгосон хувьцаат компанийн нийт хувьцааны 5 хүртэл хувийг эзэмшдэг бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзнэ.

Зургаа. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг олон нийтэд мэдээлэх, хадгалах

6.1.ХОМ-ийн хураангуйг жил бүрийн 2 дугаар улиралд багтаан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийн хураангуйг холбогдох хуульд заасан хугацаанд Авлигатай тэмцэх газраас хөтлөх Мэдүүлгийн ил тод байдлын цахим систем (<http://хасхот.iaас.mn/>)-д нээлттэй байршуулна.

6.2.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан мэдээлэл авч болох бөгөөд мэдээлэл өгөхтэй холбоотой харилцааг тусгай журмаар зохицуулна.

Долоо. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар баталгааны
маягтыг хадгалах

7.1. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, баталгааны маягт, тэдгээртэй холбоотой бүртгэл, тайлан мэдээг энэхүү журмын 2.1, 2.2-т зааснаар хүлээн авч, бүртгэсэн байгууллага хадгална.

7.2. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар болон бусад баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт шилжүүлнэ.

Найм. Хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



*Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2024 оны 04 дүгээр
сарын 02-ны өдрийн 05 дугаар
тогтоолын 10 дугаар хавсралт*

МЭДҮҮЛЭГ ГАРГАХ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

1. Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасны дагуу дараах албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргана:

1.1. Монгол Улсын Их Хурлаас тогтоосон төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй зэрэг зиндаа адилтгах албан тушаалтан.

1.2. Төрийн улс төрийн албан тушаалтан, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, хот, тосгоны захирагч, улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх (улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны туслах, хэвлэл мэдээллийн ажилтан, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаалтан хамаарахгүй).

1.3. Төрийн захиргааны албаны “АА-1”-“АА-8”, “ТЗ-1”-“ТЗ-7”-д хамаарах албан тушаалтан (шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хамаарахгүй);

1.4. Төрийн тусгай албаны дараах албан тушаалтан. Үүнд:

1.4.1. Бүх шатны шүүхийн шүүгч;

1.4.2. Бүх шатны прокурор;

1.4.3. Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

1.4.4. Төрийн аудитын байгууллагын Ерөнхий аудитор, түүний орлогч, тэргүүлэх аудитор, дарга, захирал, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч;

1.4.5. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, Худалдааны төлөөлөгчийн газрын дипломат албан тушаалтан, ахлах мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч;

1.4.6. Гаалийн байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан;

1.4.7. Гадаадын иргэн, харьяатын байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан; (Энэ заалтад УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон.)

1.4.8. Батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгууллагын офицерын албан тушаалын “ТТ-1”-“ТТ-5”-д хамаарах, ахлагчийн албан тушаалын



“ТТ-1”-“ТТ-4”-д хамаарах албан тушаалтан;

1.4.9. Хил хамгаалах байгууллагын “ТТ-1”-“ТТ-5”-д хамаарах албан тушаалтан;

1.4.10. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын “ТТ”-1-“ТТ-6”-д хамаарах албан тушаалтан; *(Энэ заалтад УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон.)*

1.4.11. Тагнуулын байгууллагын “ТТТ-1”-“ТТТ-10” болон “ТТТ-1-4”-“ТТТ-1-10”-д хамаарах албан тушаалтан;

1.4.12. Цэргийн тагнуулын байгууллагын “ТТТ-3”-“ТТТ-10”-д хамаарах албан тушаалтан;

1.4.13. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын “ТТТ-1”-“ТТТ-8”-д хамаарах албан тушаалтан болон тусгай техникийн үзлэгийн ажилтан, нягтлан бодогч; *(Энэ заалтад УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон.)*

1.4.14. Цагдаагийн байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан;

1.4.15. Дотоодын цэргийн байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан;

1.4.16. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “ТТ-1”-“ТТ-6”-д хамаарах албан тушаалтан болон шийдвэр гүйцэтгэгч;

1.4.17. Шүүх шинжилгээний байгууллагын “ТТ-1”-“ТТ-3”-д хамаарах албан тушаалтан болон шинжээч, шинжээч эмч, лабораторийн эрхлэгч, нягтлан бодогч, сэтгэл зүйч, сэтгэцийн эмч;

1.4.18. Хууль сахиулагчийг бэлтгэх сургуулийн “ТТ-1”-“ТТ-4”-д хамаарах албан тушаалтан;

1.4.19. Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн “ТТ-1”-“ТТ-4”-д хамаарах албан тушаалтан;

1.5. Төрийн үйлчилгээний албаны дараах удирдах албан тушаалтан. Үүнд:

1.5.1. “ТҮШУ-4”-“ТҮШУ-7”-д хамаарах шинжлэх ухааны салбарын удирдах албан тушаалтан;

1.5.2. “ТҮМБ-5”-“ТҮМБ-6”-д хамаарах мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер;

1.5.3. “ТҮБД-4”-“ТҮБД-5”-д хамаарах сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын захирал, эрхлэгч (сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын сургалтын менежер, арга зүйч хамаарахгүй);

1.5.4. “ТҮЭМ-6”-“ТҮЭМ-9”-д хамаарах эрүүл мэндийн салбарын удирдах албан тушаалтан, түүнтэй дүйцүүлэх албан тушаалтан;

1.5.5. “ТҮСБ-5”-“ТҮСБ-7”-д хамаарах соёл, урлаг, биеийн тамир, спортын салбарын удирдах албан тушаалтан;



1.5.6. “ТҮМ-7”-“ТҮМ-10”-д хамаарах төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын удирдах албан тушаалтан;

1.5.7. Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах “ТҮ-9”-“ТҮ-12”-д хамаарах удирдах албан тушаалтан;

1.6. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой (50 ба түүнээс дээш хувийн) хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

1.7. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой (50 хүртэлх хувийн) хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлж оролцох гишүүн;

1.8. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

1.9. Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог байгууллага (хороо, зөвлөл, газар гэх мэт)-ын удирдах албан тушаалтан, орон тооны гишүүн;

1.10. Монголбанкны газар, хэлтэс /салбар, алба, төлөөлөгчийн газар/-ийн захирал, ахлах мэргэжилтэн, улсын байцаагч-хянан шалгагч, нягтлан бодогч, авлага барагдуулах ажилтан, банкны эрх хүлээн авагч, бүрэн эрхт төлөөлөгч, тусгай төлөөлөгч, мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Иргэний нисэхийн ерөнхий газрын худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн ажилтан болон менежер, түүнээс дээших зэрэглэлийн албан тушаалтнууд, Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Хадгаламж даатгалын корпораци, Монцамэ агентлагийн удирдах албан тушаалтан; *(Энэ заалтад УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон.)*

1.11. Төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсаас гадаад улстай байгуулсан Олон улсын гэрээ, хэлэлцээр, Засгийн газар хоорондын гэрээ, зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, нэгжийн удирдах албан тушаалтан;

1.12. Төрийн тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай Засгийн газрын тусгай сангийн зохицуулагч болон нэгжийн удирдах албан тушаалтан;

1.13. Ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

1.14. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн;

1.15. Төрийн тодорхой чиг үүрэг, ажил үйлчилгээг холбогдох хууль, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг Засгийн газрын бус байгууллага /төрийн бус байгууллага/, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан;



2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Монгол Улсын Их Хурлын сонгууль, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч.

3. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д заасны дагуу авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдлийг үндэслэн Авлигатай тэмцэх газрын даргаас баталсан мэдүүлэг гаргах албан тушаалтан.

---oOo---



МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ... ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ (ХАСХОМ)-ИЙН ТУХАЙ

ХАСХОМ-ийн зорилго?

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ) нь албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчил үүсэх болон үндэслэлгүйгээр хөрөнгөжихөөс урьдчилан сэргийлэх, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, нийтийн албанд шударга, ил тод байдлыг бэхжүүлэх, олон нийтийн хяналтыг бүрдүүлэхэд дэмжлэг болох зорилготой.

Хэн гаргах вэ?

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заасан албан тушаалтан ХАСХОМ гаргана.

Хэзээ мэдүүлгээ гаргах вэ?

“Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заасан албан тушаалтан нь дараахь тохиолдолд ХАСХОМ гаргана. Үүнд:

- тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор шинээр,
- цаашид албан тушаалыг эрхэлж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн,
- хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол энэ тухай ийнхүү өөрчлөлт орсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор тус тус мэдүүлгээ гаргана.

Харин тухайн жилийн мэдүүлгээ шинэчлэн гаргасан албан тушаалтан мэдүүлгээ гаргасан байгууллагын бүтцийн нэгж дотор дахин албан тушаалд томилогдсон бол ХАСХОМ-ийг 30 хоногийн дотор дахин гаргахгүй байж болно.

Хэрхэн мэдүүлэх вэ?

ХАСХОМ-ийг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем (<https://meduuleg.iaac.mn/>)-д өөрийн эрхээр нэвтрэн орж, ЭБАТ-ны үүсгэсэн мэдүүлгийг үнэн зөв гаргаж, баталгааны маягтад гарын үсэг зурж өөрийн харьяа байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

Мэдүүлэг гаргагч нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх, хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.



Хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн үндэслэлээр мэдүүлгээ гаргаж байгаа бол зөвхөн өөрчлөлт орсон хэсгийн мэдээллийг шинэчлэн мэдүүлнэ.

Үнийн дүнг төгрөгөөр илэрхийлэх нь?

Мэдүүлгийн маягт дахь мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх талбаруудыг төгрөгөөр илэрхийлж (мянга, сая гэх мэт оронд шилжүүлэхгүй) бичнэ. Хэрэв тухайн мөнгөн дүн нь гадаад валютаар илэрхийлэгдэх бол орлогыг тухайн орлого олох үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны валютын ханшаар, харин хөрөнгө, зээлийг тухайн мэдүүлэг гаргах оны урьд оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкнаас зарласан албан ёсны валютын ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцож мэдүүлнэ.

Мэдүүлэгт тусгах болон тусгахгүй хөрөнгийн үнийн доод хэмжээ?

Маягтын хөрөнгө, орлого, зээл хэсгийн “Тоног төхөөрөмж”, “Үнэт эдлэл, урлаг түүх, соёлын үнэт зүйлс” хэсэгт мэдүүлэх хөрөнгийн зах зээлийн үнийн дүнгийн хэмжээ, эсхүл энэ төрлийн хөрөнгийн зах зээлийн үнийн дүнгийн нийлбэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 ба түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй бол мэдүүлнэ. Дээр дурдсанаас бусад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, орлого, бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын данс, виртуал хөрөнгө, зээл, авлага, хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаасны хувьд ямар нэгэн үнийн дүнгийн доод хэмжээ харгалзахгүйгээр мэдүүлэгт тусгана.

Хариуцлагын тухай?

Мэдүүлэг гаргагч албан тушаалтан нь ХАСХОМ-ээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8, 33 дугаар зүйлийн 33.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь хэсэгт заасан хариуцлагыг хүлээлгэдэг. Мөн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлийн 22.10-т заасан хариуцлагыг тус тус хүлээлгэдэг.

Хамрах хугацаа?

Мэдүүлэг гаргагч тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор шинээр (Шинээр томилогдсон / сонгогдсон), цаашид албан тушаалыг эрхэлж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн (2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн), хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний



доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол энэ тухай ийнхүү өөрчлөлт орсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор (Хөрөнгө, орлогод орсон өөрчлөлт) тус тус мэдүүлгээ гаргана. Мэдүүлэг гаргахдаа дараах хамрах хугацааг баримтална.

Маягтын хэсэг	ХАСХОМ-ийг мэдүүлэхэд хамрах хугацаа		
	Шинээр томилогдсон/ сонгогдсон	2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн	Хөрөнгө, орлогод орсон өөрчлөлт
Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал	Томилогдох, сонгогдох үеийн байдлаар	Өмнөх оны 12 сарын 31-ний байдлаар	Мэдүүлэхгүй
Хоёр. Хувийн ашиг сонирхол			
Үүнээс: - Давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл - Бэлэг, хандив, өв залгамжлал	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	
Гурав. Хөрөнгө, орлого, зээл			
- Орлого	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	Өөрчлөлт орсон үеийн байдлаар, өөрчлөлт орсон хэсгийг шинэчлэн мэдүүлнэ
- Хөрөнгө (орон сууц, барилга, байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, мал, амьтан, газар, үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйл, бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын дансны үлдэгдэл, виртуал хөрөнгө, авлага, хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас, эрх, патент)	Өмнөх оны 12 сарын 31-ний байдлаар	Өмнөх оны 12 сарын 31-ний байдлаар	
- Зээл	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	



**МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ...ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН
МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН МАЯГТ
НӨХӨХ ЗААВАР**

Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

1.1. Мэдүүлэг гаргач		
Ургийн овог:	Эцэг/эхийн нэр:	Нэр:
Регистрийн дугаар: 	Байгууллагын нэр:	
Иргэний харьяалал:	Нэгж /газар, хэлтэс, тасаг, алба/-ийн нэр:	
Төрсөн газар:	Албан тушаалын нэр:	
Оршин суугаа газрын хаяг болон бусад хаяг:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:	
Боловсрол, мэргэжил:	Цахим шуудангийн хаяг:	
Гар утас: Шаардлагатай үед холбоо барих утас:	Тухайн албан тушаалд томилогдсон/сонгогдсон огноо:	
Ажлын утас:	 он сар өдөр	

1.1 Мэдүүлэг гаргагч:

- **Ургийн овог, Эцэг/эхийн нэр, Нэр:** мэдүүлэг гаргагч өөрийн иргэний бүртгэл дээр бүртгэгдсэнээр бичнэ.
- **Регистрийн дугаар:** иргэний улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу мэдүүлэг гаргагч өөрийн иргэний үнэмлэх дээрх бичигдсэн үсэг, тооноос бүтсэн нийлмэл кодыг бичнэ. Хэрэв тухайн мэдүүлэг гаргагч нь гадаад улсын иргэн бол гадаад паспортын дугаар, эсхүл Монгол Улсаас олгосон бүртгэлийн дугаарыг бичнэ.
- **Иргэний харьяалал:** аль улсын иргэн болохыг бичнэ.
- **Төрсөн газар:** төрсний гэрчилгээнд бичигдсэн нутаг дэвсгэрийн нэрийг бичнэ.
- **Оршин суугаа газрын хаяг болон бусад хаяг:** иргэний бүртгэлийн хаягийн санд бүртгэлтэй, улсын бүртгэлд бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хороолол, гудамжны нэр, байрны дугаар, газар, усны нэрийг эсхүл уг хаягаас өөр газарт амьдарч байгаа бол байнга оршин сууж байгаа хаягийг бичнэ.
- **Боловсрол, мэргэжил:** мэдүүлэг гаргагч өөрийн эзэмшсэн боловсрол, мэргэжлийн нэршлийг түүнийг нотлох албан ёсны баримт (гэрчилгээ, диплом)-д бичигдсэнээр бичнэ.
- **Гар утас, Ажлын утас:** өөрийн эзэмшиж байгаа буюу өөрийн нэр дээр бүртгэлтэй үүрэн холбооны болон ажлын газрын утасны дугаарыг бичнэ.
- **Шаардлагатай үед холбоо барих утас:** мэдүүлэг гаргагчтай



холбогдох боломжгүй тохиолдолд холбоо баривал зохих хүний нэр, түүний үүрэн холбооны эсхүл ажлын газрын утасны дугаарыг бичнэ.

- **Байгууллагын нэр, Нэгж /газар, хэлтэс, тасаг, алба/-ийн нэр, Албан тушаалын нэр:** мэдүүлэг гаргах үед ажиллаж байгаа байгууллага, нэгжийн болон албан тушаалын албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичнэ.

- **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** Төрийн албаны тухай хууль¹, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад баталгаажсанаар бичнэ.

- **Цахим шуудангийн хаяг:** өөрийн тогтмол ашигладаг, идэвхтэй цахим шуудангийн хаяг (и-мэйл)-ийг бичнэ.

- **Тухайн албан тушаалд томилогдсон/сонгогдсон огноо:** эрхэлж байгаа албан тушаалд томилогдсон/сонгогдсон он, сар, өдрийг албан ёсны баримтад бичигдсэнээр бичнэ.

- **Та мэдүүлэг гаргах үндэслэлээс аль тохирохыг сонгон** ✓ гэж тэмдэглэнэ үү. Зарим тохиолдолд 1-ээс дээш үндэслэлээр мэдүүлэг гаргахаар бол холбогдох үндэслэл бүрийг сонгоно.

- ☐ **Тухайн албан тушаалд томилогдсон/сонгогдсон/ өдрөөс хойш 30 хоногийн дотор**

- ☐ **Тухайн алба хааж байх хугацаандаа шинэчлэн гаргасан** (жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор)

- ☐ **Хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол (тухай бүр 30 хоногийн дотор)**

1.2 Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал:

1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал						
№	Таны юу болох	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар	Эрхэлж буй ажил, албан тушаалын нэр /сурч байгаа бол сургууль, цэцэрлэг г.м./	Оршин суугаа газрын хаяг
1.						

- **Таны юу болох:** мэдүүлэг гаргагчийн эхнэр/нөхөр (гэрлэгчид) тэдэнтэй хамт амьдарч байгаа, оршин суугаа засаг захиргааны нэгжийн өрхийн бүртгэлд бүртгэлтэй хүүхэд (төрсөн, дагавар, үрчлэн авсан, гадаад улсад сурч, ажиллаж байгаа) болон хуульд заасны дагуу гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийн аль нь болохыг бичнэ.

- **Эцэг/эхийн нэр, нэр, Регистрийн дугаар, Төрсөн газар:** тухайн этгээдийн иргэний бүртгэлийн мэдээллийг иргэний үнэмлэхэд

¹ <https://www.legalinfo.mn/mn/detail/13025>



бичигдсэнээр бичнэ.

• **Эрхэлж буй ажил, албан тушаалын нэр/сурч байгаа бол сургууль, цэцэрлэг г.м.:** тухайн этгээдийн ажил, албан тушаал, сургууль/цэцэрлэгийн талаарх мэдээллийг албан ёсны нэршлээр нь бичнэ.

• **Оршин суугаа газрын хаяг:** хамт амьдарч байгаа, оршин суугаа засаг захиргааны нэгжийн өрхийн бүртгэлд бүртгэлтэй этгээдийн тухайд энэ хэсэгт ямар нэг бичиглэл хийхгүй. Мэдүүлэг гаргагчийн эхнэр/нөхөр (гэрлэгчид) тэдэнтэй хамт амьдарч байгаа, оршин суугаа засаг захиргааны нэгжийн өрхийн бүртгэлд бүртгэлтэй хүүхэд нь гадаад улсад сурч, ажиллаж байгаа бол түүнийг албан ёсны нэршлээр нь бичнэ.

ХОЁР. ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ: Мэдүүлэг гаргагч нь албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг² ойлгох ба нийтийн албан тушаалд шинээр сонгогдсон/томилогдсон бол тухайн үеийн байдлаар, шинэчлэн гаргаж байгаа бол өмнөх оны 12 дугаар сарын 31-ний байдлаар мэдүүлнэ.

2.1 Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд:

2.1 Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд					
№	Таны юу болох	Хамаарал бүхий этгээдийн нэр	Төрсөн газар	Ажиллаж байгаа байгууллагын нэр /сурч байгаа бол сургууль/	Эрхэлж байгаа албан тушаалын нэр
1.					

• Мэдүүлэг гаргагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр (нөхөр)-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү зэргээс аль нь болох, түүнд хамаарах мэдээллийг албан ёсны нэршлээр нь бичнэ.

• Энэ маягт, зааврын “1.2 Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал”-д бичсэн гишүүдийн талаарх мэдээллийг бичихгүй.

² Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль., 3 дугаар зүйл., 3.1.2

**2.2 Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд:**

2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд				
№	Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл	Тайлбар
1.				

• Компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нэр болон үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч, эцсийн өмчлөгч, ашиг хүртэгч, хуулийн этгээдийн хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг эзэмшиж байгаа аль нь болох, түүнд хамаарах мэдээллийг бичнэ.

• Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн гишүүн нь ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой бөгөөд “1.2 Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал” хэсэгт мэдүүлсэн бол давхардуулан бичихгүй.

• **Тайлбар:** дээр дурдсанаас гадна нэмэлтээр, шаардлагатай гэж үзэж байгаа (хаана, хэзээ, ямар үйл ажиллагаагаар хамааралтай гэх мэт) мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

2.3 Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл:

2.3 Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл					
№	Төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага, төлөөлөн удирдах зөвлөл зэрэг гишүүнчлэл бүхий байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үүсгэн байгуулагч, дарга, гүйцэтгэх захирал, гишүүний аль нь болох	Элссэн огноо	Тайлбар
1.					

• Энэхүү талбарт дурдсан гишүүнчлэл бүхий байгууллагын талаарх мэдээллийг улсын бүртгэлийн албан ёсны баримтад бичигдсэнээр бичнэ.

• **Тайлбар:** дээр дурдсанаас гадна нэмэлтээр, шаардлагатай (хаана, хэзээ, ямар үйл ажиллагаагаар хамааралтай гэх мэт) мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

**2.4 Өөрийн болон хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхол:**

2.4. Та болон таны хамаарал бүхий этгээд нь таны ажиллаж байгаа байгууллага /түүний салбар, нэгж/-д сүүлийн 2 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд шалгарах, тусгай зөвшөөрөл авах, гэрээ, контракт байгуулах, хяналт шалгалт явуулах, хариуцлага хүлээлгэх зэрэг үйл ажиллагаанд оролцсон эсэх (аль тохирохыг сонгон ү тэмдэглэгээ хийнэ).

☐ Тийм бол, тодорхой бичих.

☐ Үгүй

• ☐ **Тийм бол, тодорхой бичих.** гэх сонголтыг хийсэн бол тухайн нийтийн албан тушаалтны хамаарал бүхий этгээд болох эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр / нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийн аль нэг нь сүүлийн 2 жилийн хугацаанд таны ажиллаж байгаа байгууллага (түүний салбар, нэгж)-аас зохион байгуулсан худалдан авах ажиллагаа (тендер)-д шалгарсан, тусгай зөвшөөрөл авсан, гэрээ контракт байгуулсан, хяналт шалгалт явуулсан, хариуцлага хүлээлгэсэн зэрэг үйл ажиллагаанд оролцсон бол энэ тухай дэлгэрэнгүй бичнэ.

2.5 Давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:

2.5. Давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл				
№	Байгууллагын нэр	Албан тушаалын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тайлбар
1.				

• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль³-ийн 18 дугаар зүйл (Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт)-д заасан болон тухайн жилд эрхэлсэн давхар ажил эрхлэлтийн мэдээллийг хамтад нь бичнэ.

• Мэдүүлэг гаргагч өөрийн томилогдсон/сонгогдсон албан тушаалаас гадна ямар байгууллагад, ямар ажил, албан тушаалыг, ямар үйл ажиллагааны чиглэлээр гүйцэтгэснийг тохирох талбарт, давхар ажил эрхлэлт үргэлжилж байгаа бол эхэлсэн хугацааг, богино хугацаанд эрхэлсэн бол мөн хугацааг, ийнхүү давхар ажил эрхэлж байгааг нотлох албан ёсны баримтын нэр, огноо болон холбогдох бусад мэдээллийг Тайлбар хэсэгт тодорхой бичнэ.

• “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар /аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар/-т төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн бол энэ тухай бичнэ.

³ <https://legalinfo.mn/mn/detail/397>

**2.6 Бэлэг, хандив, өв залгамжлал:**

№	Эх сурвалжийн нэр (бэлэг, өв залгамжлал, хандив өгсөн хувь хүн, хуулийн этгээд)	Ямар хамааралтай болох	Огноо	Бэлэг, хандив, өв залгамжлалын аль нь болох	Хүлээн авсан эд хөрөнгө / эрх/-ийн нэр	Зориулалт	Үнэлгээ (төгрөгөөр)	Тайлбар
1.								
Нийт дүн								

- Мэдүүлэг гаргагч:
 - гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс;
 - нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан, тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс;
 - хуульд зааснаар хүлээн авсан хандив, өвлөгдсөн эд хөрөнгө, эрхийн зах зээлийн үнэлгээг төгрөгөөр илэрхийлэн мэдүүлнэ.
- **Бэлэг:** нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг ойлгоно.
- **Хандив:** нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг ойлгоно.
- **Өв залгамжлал:** Иргэний хууль⁴-д зааснаар хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгдсөн эд хөрөнгө, эрхийг ойлгоно.
- **Эх сурвалжийн нэр:** бэлэг, хандив өгсөн, өв өвлүүлсэн хувь хүний эцэг/эхийн нэр, өөрийнх нь нэрийг, хуулийн этгээдийн нэрийг улсын бүртгэлд бүртгэгдсэнээр товчлохгүй, тодорхой бичнэ.
- **Ямар хамааралтай болох:** бэлэг, хандив өгсөн, өв өвлүүлсэн этгээдтэй мэдүүлэг гаргагч нь ямар хамааралтай болохоо бичнэ.
- **Огноо:** бэлэг, өв залгамжлал, хандивыг хүлээн авсан он, сар, өдрийг бичнэ.
- **Хүлээн авсан эд хөрөнгө /эрх/-ийн нэр:** хүлээн авсан бэлэг, өв залгамжлал, хандиваар авсан хөрөнгө /эрх/-ийн нэрийг бичнэ.
- **Зориулалт:** хүлээн авсан бэлэг, өв залгамжлал, хандиваар авсан хөрөнгө /эрх/-ийг арга хэмжээ, үйл явдалд зориулан/тохиолдуулан өгсөн талаар тодорхой бичнэ.
- **Үнэлгээ:** тухайн жилийн эцсийн байдлаар зах зээлийн үнэлгээг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
- **Тайлбар:** дээр дурдсанаас гадна нэмэлтээр, шаардлагатай гэж үзэж байгаа мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

⁴ <https://legalinfo.mn/mn/detail/299>



• **Нийт дүн:** бэлэг, хандив, өв залгамжлалын үнэлгээний нийлбэр дүнг бичнэ.

ГУРАВ. ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЗЭЭЛ: Мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал буюу хуанлийн 1 жилийн хугацаан дахь хөрөнгө, орлого, зээлийг үнэн, зөв мэдүүлнэ. Үүнд:

3.1. Орлого			
№	Орлогын төрөл	Орлогын нийт дүн (төгрөгөөр)	
		Өөрийн	Гэр бүлийн гишүүний
1.	Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		
2.	Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого (албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал)		
3.	Үйл ажиллагааны орлого (үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого, цахим болон интернэт сүлжээний борлуулалтын орлого)		
4.	Хөрөнгийн орлого (түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого)		
5.	Хөрөнгө борлуулсны орлого (хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны, шилжүүлсний орлого)		
6.	Хандивын орлого (бусдаас авсан мөнгөн хандив, тусламж)		
7.	Бусад орлого (шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого гэх мэт)		
Нийт дүн			

3.1 Орлого: Тухайн жилд өөрийн болон гэр бүлийн гишүүний олсон орлогыг төрөл тус бүрээр татвар, шимтгэл төлсний дараах нийт дүнгээр бичиж, эх үүсвэрийг тайлбарлана.

1. Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн тухайн календарийн жилд авсан цалин хөлснөөс татвар, шимтгэлийг хасч тооцсон цэвэр дүнг ажил олгогчийн албан ёсны баримтыг үндэслэн бичнэ.

• Хувь хүний орлогын албан татварын тухай хууль⁵-д заасан дараах орлогыг хамруулна. Үүнд:

➢ эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин, цалингийн сүлжээ, ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; Нийт мөнгөн дүнгээс шагнал, урамшууллын мөнгөн дүнг хассан дүнг бичнэ.

➢ ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;

5 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14410>, 7 дугаар зүйл



➤ ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;

➤ төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, тэдгээртэй адилтгах орлого; Шагнал, урамшууллыг энэ хэсэгт бичихгүй.

➤ үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; Шагнал, урамшууллыг энэ хэсэгт бичихгүй.

➤ хоол, унааны мөнгө.

2. Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого (албан байгууллага болон хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал): өөрийн болон гэр бүлийн гишүүдийн тухайн хуанлийн жилд авсан ажил олгогчоос олгосон шагнал, урамшуулал, төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний шагнал, урамшуулал, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлогыг бичнэ.

3. Үйл ажиллагааны орлого (үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого, цахим болон интернэт сүлжээний борлуулалтын орлого): өөрийн болон гэр бүлийн гишүүдийн Хувь хүний орлогын албан татварын тухай хууль⁶-д заасан дараах орлогыг бичнэ.

➤ бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого;

➤ хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

➤ шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

➤ эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээнээс олсон орлого;

➤ тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлого-цахим болон интернэт сүлжээг ашиглан олсон орлого.

4. Хөрөнгийн орлого: Хувь хүний орлогын албан татварын тухай хууль⁷-д заасан дараах орлогыг бичнэ.

➤ хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого;

➤ эрхийн шимтгэлийн орлого;

о Зохиогчийн эрх⁸ болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд

6 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14410>, 8 дугаар зүйл

7 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14410>, 9 дүгээр зүйл

8 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230812154721>



заасны дагуу зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

о Патентын тухай хууль⁹-д заасны дагуу шинэ бүтээл, бүтээгдэхүүн болон ашигтай загвар ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

о Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль¹⁰-д заасны дагуу барааны тэмдэг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

о Технологи дамжуулах тухай хууль¹¹-д заасны дагуу технологи дамжуулсны төлбөр, үйлдвэр, худалдаа, шинжлэх ухааны туршилттай холбоотой мэдээллийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр; үйлдвэр, худалдаа, шинжлэх ухааны туршилтын тоног төхөөрөмжийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр, эдгээртэй адилтгах бусад эрх ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

➤ ногдол ашгийн орлого:

о хувьцаа эзэмшил, нөхөрлөлийн буюу хамтран ажиллах гэрээнээс олсон мөнгөн болон мөнгөн бус орлого, ашгийн хувь, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг гэж үзэх бусад орлого;

➤ хүүгийн орлого:

о барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн хөрөнгөд оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өр, өглөг, харилцах болон хадгаламжийн данс, баталгаа, батлан даалт, зээл, зээллэг, бонд, өрийн хэрэгсэл болон тэдгээрийн урамшуулал зэрэгтэй шууд холбогдуулан зээлдэгчээс олгосон орлого, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүүгийн орлого гэж үзэх бусад орлого.

5. Хөрөнгө борлуулсны орлого (хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны, шилжүүлсний орлого):

➤ үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;

➤ газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

➤ хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;

➤ хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого.

➤ Биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар төлөгч өөрийн эдийн бус хөрөнгө өмчлөх эрхийг хуульд заасны дагуу бусдад шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.

6. Хандивын орлого (Бусдаас авсан мөнгөн хандив, тусламж):

• Иргэн, хуулийн этгээдээс тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлснийг хандив гэж ойлгох ба эдгээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө, үйлчилгээг тухайн үеийн зах зээлийн үнээр тооцон мөнгөн

9 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231112526381>

10 <https://legalinfo.mn/mn/detail/111>

11 <https://legalinfo.mn/mn/detail/477>



дүнд шилжүүлснээр бичнэ.

• Энэхүү зааврын 2.6 дахь хэсэгт мэдүүлсэн хандив үүнд хамаарна.

7. Бусад орлого: дээр зааснаас бусад орлого, нөхөн төлбөр, санхүүгийн дэмжлэг, тэтгэмж, тусламж, буцаан олголт зэрэг орлогыг хамааруулна. Үүнд: спорт урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого, бусдаас авсан авлагын орлого гэх мэт.

3.2 Орон сууц, барилга, байгууламж:

3.2. Орон сууц, барилга, байгууламж								
№	Орон сууц, барилга, байгууламжийн төрөл	Улсын бүртгэлийн дугаар	Байршил /хаяг/	Хийц, талбайн хэмжээ, өрөөний тоо	Өмчлөгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Анхны үнэ (төгрөг)	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.								
					Нийт дүн			

• Монгол Улс болон гадаад улс, оффшор бүс дэх өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөл, эзэмшилд байгаа дараах орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ.

➤ Эд хөрөнгийн улсын бүртгэлд “өмчлөлд байгаа” бүртгэлтэй, хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэр;

➤ Бүртгэлгүй буюу баригдаж дуусаагүй, баригдсан боловч албан ёсоор гэрчилгээ аваагүй г.м дуусаагүй барилга;

➤ Газраас салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмсад хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж, авто зогсоол, гараж, хашаа байшин, зуслангийн байр, хүлэмж, өвөлжөө, хаваржаа, намаржаа, түүнтэй адилтгах байшин, сууц, гэр;

➤ Гадаад улс, оффшор бүс дэх орон сууц, барилга, байгууламж.

• **Орон сууц, барилга, байгууламжийн төрөл:** Барилгын тухай хууль болон барилга байгууламжийн норматив баримт бичигт зааснаар өөрийн болон гэр бүлийн гишүүний орон сууцны бүтээц нь блок, дүнз, палк, тоосго, төмөр краказ, угсармал бетон, цутгамал, чулуун, шавар, модон, эсгийн аль нь болохыг бичнэ. Баригдаж дуусаагүй, захиалга өгсөн байр бол “Дуусаагүй барилга” гэж бичнэ.

• **Улсын бүртгэлийн дугаар:** үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэнээр бичнэ. Хэрэв улсын бүртгэлд бүртгэгдээгүй бол холбогдох хэсгийн тайлбарт тодорхой бичнэ. “Дуусаагүй барилга” бол энэ хэсэгт 000 гэж бичнэ.



• **Байршил (хаяг):** үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэнээр, гадаад улс, оффшор бүсэд байгаа бол түүнийг нотлох албан ёсны баримтад бичигдсэнээр, дуусаагүй барилга бол орон сууц, барилга байгууламжийн захиалгын гэрээнд зааснаар бичнэ.

• **Хийц, талбайн хэмжээ, өрөөний тоо:** үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээнд эсхүл хүчин төгөлдөр бүхий бусад баримтад, дуусаагүй барилга бол орон сууц захиалгын гэрээнд зааснаар бичнэ.

• **Өмчлөгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:** үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээнд эсхүл бусад албан ёсны баримт бол гадаад улсын бүртгэлийн баримт, захиалгын гэрээнд бичигдсэнээр бичнэ.

• **Анхны үнэ (төгрөг):** тухайн хөрөнгийг барьж байгуулах, бий болгоход зарцуулсан, эсхүл анх худалдан авахад мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдээс төлсөн үнэ, дуусаагүй барилга бол захиалгын гэрээнд бичигдсэн захиалгын үнийг бичнэ. Гадаад улс, оффшор бүсэд байгаа бол орон сууц, барилга, байгууламжийн үнийг, доллар, евро өөр бусад валютаар худалдан авч өмчилсөн бол тухайн мөнгөн тэмдэгт, валютаар баталгаажсан дүнг тухайн үеийн ханшаар төгрөгт хөрвүүлсэн дүнтэй хамт бичнэ.

• **Зах зээлийн үнэлгээ (төгрөг):** орон сууц, барилга, байгууламж нь Монгол Улсад байгаа бол жилийн эцсийн зах зээлийн үнээр, гадаад улс, оффшор бүсэд байгаа бол тухайн жилийн эцсийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлэн төгрөгөөр илэрхийлж бичнэ.

• **Эх үүсвэрийн тайлбар:** тухайн орон сууц, барилга, байгууламжийг өөрийн өмчлөлд шилжүүлэн авсан огноо, үнэ, санхүүгийн болон бусад эх үүсвэр (цалингийн хуримтлал, бэлэг, өв залгамжлал, зээл гэх мэт)-ийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

3.3 Тээврийн хэрэгсэл:

3.3. Тээврийн хэрэгсэл							
№	Тээврийн хэрэгслийн зориулалт, марк, үйлдвэрлэсэн он	Өмчлөгч/ эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр	Улсын дугаар	Арлын дугаар	Анхны үнэ (төгрөг)	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.							
Нийт дүн							

➤ **Автотээврийн тухай хууль¹², Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль¹³, Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэм¹⁴-д заасан:**

о хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгсэл төрлийн ачааны болон суудлын

¹² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=29>

¹³ <https://legalinfo.mn/mn/detail/11224>

¹⁴ <https://legalinfo.mn/mn/detail/13641>



автомашин, автобус;

о механикжсан тээврийн хэрэгслээр чирэхэд зориулсан тээврийн хэрэгсэл болох чиргүүл;

о мотоцикл;

о үйлдвэрлэгчээс тусгайлан тоноглогсон тээвэрлэлтийн зориулалт бүхий автомашин,

о бусад хүн болон ачаа тээвэрлэхэд зориулагдаагүй тусгай зориулалт бүхий автомашин, трактор, авто чиргүүл, үр тарианы комбайн, мопедоос бусад хөдөлгүүрээр тоноглогдсон механикжсан тээврийн хэрэгслийг;

➤ **Усан замын тээврийн тухай хуульд заасан** усан замаар зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн усан онгоц, чирэгч онгоц, чиргүүл онгоц, шумбагч онгоц, ахуйн болон спортын зориулалттай завь, хийлдэг завь, усны мотоцикл, хөвөгч төхөөрөмж, инженерийн хөвөгч байгууламжийг;

➤ **Иргэний нисэхийн тухай хуульд заасан** агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах аливаа төхөөрөмж буюу бүх төрлийн нисдэг тэрэг, нисэх онгоцыг.

• **Тээврийн хэрэгслийн зориулалт, марк, үйлдвэрлэсэн он:** өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөл, эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл тус бүрийн, марк, үйлдвэрлэсэн он, ямар зориулалттай болохыг тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг албан ёсны баримт, бүртгэлд бичигдсэнээр бичнэ.

• **Өмчлөгч/эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр:** тухайн төрлийн тээврийн хэрэгсэл хэний өмчлөл/эзэмшилд байгааг албан ёсны баримтад дурдсанаар бичнэ.

• **Улсын дугаар, Арлын дугаар:** тухайн төрлийн тээврийн хэрэгсэлд эрх бүхий байгууллагаас олгосон бөгөөд албан ёсны баримтад баталгаажсан улсын дугаар болон арлын дугаарыг мэдүүлнэ.

• **Анхны үнэ (төгрөг):** тухайн хөрөнгийг өөрийн болгоход зарцуулсан, эсхүл анх худалдан авахад мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдээс төлсөн үнийн дүнгээр илэрхийлэгдэх мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

• **Зах зээлийн үнэлгээ (төгрөг):** мэдүүлж байгаа тээврийн хэрэгслийн үнэлгээг тухайн жилийн эцсийн үнэлгээгээр, төгрөгөөр илэрхийлж бичнэ.

• **Эх үүсвэрийн тайлбар:** өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөлд байгаа тухайн тээврийн хэрэгслийн өмчилж, эзэмшиж эхэлсэн огноо, түүний санхүүгийн болон бусад эх үүсвэр (цалингийн хуримтлал, бэлэг, өв залгамжлал, зээл гэх мэт)-ийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

3.4 Тоног төхөөрөмж:



3.4. Тоног төхөөрөмж					
№	Тоног төхөөрөмжийн нэр, зориулалт, марк, үйлдвэрлэсэн он	Өмчлөгч/зээмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Анхны үнэ / төгрөг/	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.					
Нийт дүн					

Мэдүүлэг гаргагч өөрийн болон түүний гэр бүлийн гишүүний өмчлөл, эзэмшилд байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 ба түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий, маягтын бусад хэсэгт мэдүүлээгүй хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж (ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, цахилгаан бараа, галт зэвсэг гэх мэт)-ийг мэдүүлнэ.

➤ **Тоног төхөөрөмжийн нэр, зориулалт, марк, үйлдвэрлэсэн он:** тухайн тоног төхөөрөмжийн албан ёсны баримтад бичигдсэнээр бичнэ.

➤ **Өмчлөгч/зээмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр:** тоног төхөөрөмжийг өмчилж, эзэмшиж байгаа мэдүүлэг гаргагч болон гэр бүлийн гишүүний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрийг бичнэ.

➤ **Анхны үнэ /төгрөг/:** тоног төхөөрөмжийг өөрийн өмчлөл, эзэмшилд авахад зарцуулсан, эсхүл анх худалдан авахад төлсөн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.

➤ **Зах зээлийн үнэлгээ (төгрөг):** тухайн тоног төхөөрөмжийн зах зээлийн үнэлгээг жилийн эцсийн байдлаар, төгрөгөөр илэрхийлж бичнэ.

➤ **Эх үүсвэрийн тайлбар:** тоног төхөөрөмжийг ямар эх үүсвэр (цалингийн хуримтлал, өв залгамжлал, зээл гэх мэт)-ээр өмчлөл/эзэмшил/-д авсан тухай дэлгэрэнгүй мэдүүлнэ.

3.5 Мал, амьтан:

3.5. Мал, амьтан						
№	Өмчлөгч, зээмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр	Төрөл	Тоо, толгой	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Байршил	Эх үүсвэрийн тайлбар
1.						
Нийт дүн						

Мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөл, эзэмшилд байгаа дараах мал, амьтны төрөл, тоо толгойг зах зээлийн үнэлгээ, тухайн нутаг дэвсгэрийн байршил, өөрийн болон гэр бүлийн өмчлөлд байдаг боловч бусдаар маллуулдаг, эсхүл эрхлүүлдэг бол тухайн хүний нэр, харьяалал, хаягийн мэдээллийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

➤ албан ёсны данс бүртгэлд тусгагдсан уламжлагдан маллаж ирсэн таван хошуу мал;

➤ ашиг шимийг нь ашиглах зорилгоор гэршүүлэн үржүүлж байгаа амьтан (гахай, тахиа, зөгий, нохой, шувуу, бусад амьтан).

• **Эх үүсвэрийн тайлбар:** мэдүүлсэн мал, амьтныг өмчлөл,



эзэмшилд олж авсан эх үүсвэрийн талаар дэлгэрэнгүй мэдүүлнэ.

3.6 Газар:

3.6. Газар							
№	Өмчлөгч/эзэмшигч/ашиглагчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Эрхийн төрөл, огноо /өмчлөх/эзэмших/ашиглах/	Улсын бүртгэлийн дугаар	Зориулалт, хэмжээ, хугацаа	Байршил (бүс нутаг), хаяг	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.							
					Нийт дүн		

• Өөрийн болон түүний гэр бүлийн гишүүдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газарт холбогдох этгээдийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр, эрхийн төрөл (эзэмших, ашиглах, өмчлөх аль нь болох), эрх олгогдсон огноо, зориулалт /гэр бүлийн хамтын хэрэгцээний буюу гэр, орон сууц, хашаа барих, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих, давуу эрхээр эзэмшиж байгаа үр тарианы, төмс, хүнсний ногооны, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтын гэх мэт/, эрх олж авсан болон эрх шилжүүлж авсан огноо, тухайн газрын байршил буюу хаягийг тухайн эрхийг баталгаажуулсан албан ёсны баримт, бүртгэлд бүртгэгдсэнээр бичнэ.

• Зах зээлийн үнэлгээ: тухайн газрыг өөрийн эзэмшил, ашиглал, өмчлөлд авсан эх үүсвэр (төрөөс үнэгүй, худалдаж авсан, эрх шилжүүлж үнэгүй авсан, дуудлага худалдаа, төсөл, сонгон шалгаруулалт, өв залгамжлал гэх мэт)-ийг тодорхой бичнэ.

• Нийт дүн: газрын үнэлгээний нийлбэр дүнг бичнэ.

3.7 Үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйл:

3.7 Үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйл				
№	Хөрөнгийн нэр	Үнэлгээ (төгрөг)	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн тайлбар
1.				
Нийт дүн				

Өөрийн болон түүний гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд ашиглаж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 ба түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний үнэ бүхий үнэт металл (алт, мөнгө, цагаан алт, паллади), үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйл (хөрөнгө)-ийн нэр, эзэмшигчийн нэр, зах зээлийн үнэлгээг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

• **Эх үүсвэрийн тайлбар:** тухайн хөрөнгийг анх хэзээ өөрийн болгож авсан, хэрэв худалдан авсан бол ямар үнээр, хэнээс, хаанаас худалдан авсан зэргээ тайлбарлан бичнэ.

3.8 Бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын дансны үлдэгдэл



/өмнөх оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/:

3.8. Бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын дансны үлдэгдэл /өмнөх оны 12-р сарын 31-ний байдлаар/						
№	Бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж, карт, данс эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Хадгаламж/данс/карт эзэмшиж байгаа банк, санхүүгийн байгууллагын нэр, байршил	Дансны төрөл	Дансны дугаар	Мөнгөн дүн (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.						
Нийт дүн						

• Үндэсний төлбөрийн системийн тухай хууль¹⁵, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль¹⁶-д зааснаар мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний:

➢ Монгол улс дахь болон гадаад улсын банк, санхүүгийн байгууллага, оффшор бүс дэх банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа бэлэн мөнгө, гадаадын мөнгөн тэмдэгт, гадаадын валют, мөнгөн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, төлбөр төлөх зориулалттай төлбөрийн карт, цахим мөнгө;

➢ Монголбанкны зөвшөөрөл бүхий биет, биет бус хэрэгсэл дэх данс, олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагын стандарт болон Монголбанкны шаардлагыг нэгэн зэрэг, эсхүл аль нэгийг нь хангасан карт эзэмшигчид төлбөр хийх боломж олгодог төлбөрийн хэрэгсэл буюу картын үлдэгдэл;

➢ Хадгаламж, харилцах данс, хадгаламжийн хайрцагт хадгалуулсан мөнгө;

➢ гар дээр хадгалагдаж байгаа бэлэн мөнгө.

• Гадаад валютыг мэдүүлэгт хамаарах жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн Монголбанкнаас зарласан ханшаар төгрөгт хөрвүүлэн дүнг мэдүүлнэ.

• **Өөрийн болон гэр бүлийн гишүүний бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж, карт, данс эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр, Хадгаламж/данс/карт эзэмшиж байгаа банк, санхүүгийн байгууллагын нэр, байршил:** өөрийн болон гэр бүлийн гишүүний нэр дээр эзэмшиж байгаа Монгол Улс болон гадаад улс, оффшор бүс дэх банк, санхүүгийн байгууллагын албан ёсны нэршил, байршлын албан ёсны нэрийг тодорхой, жагсаан бичнэ.

• **Дансны төрөл, Дансны дугаар:** банкны болон харилцах дансны төрөл (хадгаламж (хугацаатай, хугацаагүй)-ийн, цалингийн, энгийн харилцах гэх мэт), дансны дугаарыг бичнэ.

• **Мөнгөн дүн /төгрөг/:** тухайн банк, санхүүгийн байгууллага, оффшор бүс дэх банк/харилцах данс/банкны картад хадгалагдаж байгаа мөнгөн хөрөнгө болон бэлэн мөнгөний нийт дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ. Ийнхүү мэдүүлэхэд доод, эсхүл дээд хязгаар хамаарахгүй.

¹⁵ <https://legalinfo.mn/mn/detail/12668>

¹⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390242606091>



• **Эх үүсвэрийн тайлбар:** банк, санхүүгийн байгууллага, оффшор бүс дэх банк /харилцах данс/банкны картад байгаа мөнгө хөрөнгийн эх сурвалж буюу үүсвэрийг тодорхой бичнэ.

• Кредит /зээлийн/ картны мэдээллийг энд мэдүүлэхгүй бөгөөд үүнийг энэхүү маягт зааврын 3.11.Зээл хэсэгт мэдүүлнэ.

3.9 Виртуал хөрөнгө:

3.9. Виртуал хөрөнгө (криптовалют, койн, токен, NFT г.м.) /								
№	Эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Виртуал хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Анхны үнэ (төгрөг)		Зах зээлийн үнэлгээ (төгрөг) (өмнөх оны 12-р сарын 31-ний байдлаар)		Эх үүсвэрийн тайлбар
				Нэгжийн үнэ	Нийт үнэлгээ	Нэгжийн үнэ	Нийт үнэлгээ	
1.								
Нийт дүн								

• Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн өмчлөл/ эзэмшилд байгаа аливаа хэлбэрийн виртуал хөрөнгө буюу криптовалюта, койн, токен, NFT (Nonfungible tokens) зэргийг мэдүүлнэ.

• **Эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:** виртуал хөрөнгө эзэмшигчийн буюу мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг төрөл бус бүрээр нь жагсаан бичнэ.

• **Виртуал хөрөнгийн нэр, Тоо ширхэг:** тухайн виртуал хөрөнгийн нэрийг латин үсгээр Bitcoin, Ethereum, Tether, USD coin зэрэг хэлбэрээр, мөн тэдгээрийг тоо ширхгийг бичнэ.

• **Анхны үнэ (төгрөг):** тухайн хөрөнгийг бий болгоход зарцуулсан, эсхүл анх худалдан авахад мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдээс төлсөн үнийн дүнгээр илэрхийлэгдэх мөнгөн дүнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.

• **Зах зээлийн үнэлгээ:** мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн эзэмшиж буй виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээг урьд оны 12 дугаар сарын 31-ний байдлаар мэдүүлнэ.

• **Эх үүсвэрийн тайлбар:** тухайн хөрөнгийг бий болгох, худалдан авахад зарцуулсан хөрөнгийн эх үүсвэрийг дэлгэрэнгүй бичнэ.

• **Нийт дүн:** үнэлгээний нийлбэр дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

3.10 Авлага:

3.10. Авлага						
№	Хувь хүн/хуулийн этгээдийн нэр	Авлага үүссэн огноо	Дүн /төгрөг/	Хүү/алданги	Авлагын үлдэгдэл (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.						
Нийт дүн						



- Бусад хувь хүн, хуулийн этгээдэд буцаан авах нөхцөлтэйгөөр өгсөн, зээлдүүлсэн (хүүтэй эсхүл хүүгүй) мөнгө, эд хөрөнгийг мэдүүлнэ.
- Хувь хүн/хуулийн этгээдийн нэр: авлага (зээл)-ыг эргүүлэн төлбөл зохих хувь хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийнх нь нэр, хуулийн этгээд бол албан ёсны нэрийг бичнэ.
- Авлага үүссэн огноо: Иргэний хуульд зааснаар зээлийн гэрээ байгуулсан бол тухайн гэрээ байгуулсан хугацаа буюу он, сар, өдрийг бичнэ.
- **Дүн /төгрөг/:** авлага (зээл)-ын нийт дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
- **Хүү/алданги:** Иргэний хуульд зааснаар байгуулсан зээлийн гэрээнд тусгасан хүүгийн хэмжээ, хугацаа алдсан тохиолдолд тооцон авахаар тохирсон алданги/торгуулийн хэмжээг бичнэ.
- **Авлагын үлдэгдэл (төгрөг):** авлага (зээл)-ын үлдэгдлийг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
- **Эх үүсвэрийн тайлбар:** ямар хөрөнгө, эх үүсвэрээс авлага үүс (бусдад зээлдүүлсэн) талаар тодорхой бичнэ.
- **Нийт дүн:** бусдаас авбал зохих авлага, түүний хүү, авлагын үлдэгдлийг нийлбэр дүнгээр, төгрөгөөр илэрхийлж бичнэ.

3.11 Зээл:

3.11. Зээл									
№	Зээл авсан хүний эцэг/эх/-ийн нэр, нэр	Зээлдүүлэгчийн нэр	Зээлийн хэмжээ (төгрөг)	Зээл авсан болон төлж дуусах огноо	Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн нийт дүн (төгрөг)	Зээлийн үлдэгдэл (төгрөг)	Зориулалт	Зээлийн барьцаа, батлан даагч	Тайлбар
1									
Нийт дүн									

- Арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, Засгийн газрын тусгай сан, санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаа явуулдаг бүх төрлийн сан, төсөл, хөтөлбөр, хувь хүн, хуулийн этгээдээс гэрээ, хэлцлийн дагуу тогтоосон хугацаанд буцаан төлөх нөхцөлтэйгөөр авсан (хүүтэй болон хүүгүй) мөнгө буюу зээлийг урьд оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон мэдүүлнэ.
- Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эзэмшдэг кредит (зээлийн) картын талаарх мэдээлэл үүнд хамаарна.
- **Зээл авсан хүний эцэг/эх/-ийн нэр, нэр:** мэдүүлэг гаргагч өөрийн эсхүл зээл авсан гэр бүлийн гишүүний эцэг/эх/-ийн нэр, өөрийнх нь нэрийг зээлийн гэрээ болон холбогдох бусад албан ёсны баримтад бичигдсэнээр бичнэ.
- **Зээлдүүлэгчийн нэр:** мөнгө, эд хөрөнгийг зээл өгсөн хувь хүний эцэг/эх/-, өөрийнх нь нэр, арилжааны банк, банк бус санхүүгийн



байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, Засгийн газрын тусгай сан, санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаа явуулдаг бүх төрлийн сан, төсөл, хөтөлбөр, холбогдох бусад хуулийн этгээдийн албан ёсны нэрийг зээлийн гэрээ болон холбогдох бусад албан ёсны баримтад бичигдсэнээр бичнэ.

- **Зээлийн хэмжээ (төгрөг):** анх авсан зээлийн нийт хэмжээг зээлийн гэрээ болон холбогдох бусад албан ёсны баримтад бичигдсэнээр бичнэ.

- **Зээл авсан болон төлж дуусах огноо:** зээл анх авсан болон төлж дуусах он, сар, өдрийг гэрээнд зааснаар бичнэ.

- **Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн нийт дүн (төгрөг):** зээл болон зээлийн хүүд төлсөн мөнгөний нийлбэр дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

- **Зээлийн үлдэгдэл (төгрөг):** тухайн жилийн зээлийн үлдэгдлийг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

- **Зээл авсан болон төлж дуусах огноо:** зээлийн гэрээ болон холбогдох бусад албан ёсны баримтад бичигдсэн он, сар, өдрийг бичнэ.

- **Зориулалт:** зээлийн гэрээ болон холбогдох бусад албан ёсны баримтад бичигдсэн зориулалт (орон сууцны, үндсэн хөрөнгийн, эргэлтийн хөрөнгийн, хэрэглээний эргэлтийн (боловсролын, автомашины гэх мэт)-ыг бичнэ.

- **Зээлийн барьцаа, батлан даагч:** зээлийн гэрээний үүрэг биелэхгүй байх нөхцөл ирээдүйд бий болох үед гэрээний үүргийг гүйцэтгүүлэх зорилготой хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эрхийг, мөн гуравдагч этгээд зээлдэгчийн нэрийн өмнөөс зээлийн гэрээний үүргийг эд хөрөнгөөр болон орлогоороо хариуцан төлөх үүрэг хүлээсэн этгээдийг гэрээнд зааснаар бичнэ.

- **Тайлбар:** дээр дурдсанаас гадна нэмэлтээр, шаардлагатай гэж үзэж байгаа мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

3.12 Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас:

3.12. Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас						
№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувь нийлүүлсэн/оруулсан хөрөнгийн хэмжээ (төгрөг), хувь	Хөрөнгө оруулалтын төрөл, тоо	Нэгж хувьцааны анхны үнэ (төгрөг)	Тухайн жилд авсан ногдол ашиг (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.						
	Нийт дүн					

- Өөрийн болон гэр бүлийн гишүүний Монгол Улсад, гадаад улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулсан, хувь нийлүүлсэн хуулийн этгээд (хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани, толгой компани, охин компани, хараат компани, компанийн нэгдэл, салбар, төлөөлөгчийн газар), нөхөрлөл зэрэг ашгийн төлөө хуулийн этгээдэд



оруулсан хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ, хувьцааны анхны үнийг, төгрөгөөр илэрхийлэгдэх ногдол ашгийн хэмжээг, ийнхүү хөрөнгө оруулсан (худалдан авсан) эх үүсвэрийг урьд оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тасалбар болгон тодорхой бичнэ.

• Засгийн газрын болон бусад бонд, үнэт цаас (компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх, хадгаламжийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх /варрант/, Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гэж тогтоосон бусад санхүүгийн хэрэгсэл, үүсмэл санхүүгийн хэрэгсэл (derivativ)¹⁷,¹⁸, вексель¹⁹, хувьчлалын үнэт цаас/тасалбар нь хөрөнгө оруулалтын төрөлд хамаарна.

3.13 Эрх, патент:

3.13. Эрх, патент				
№	Төрөл	Эзэмшигчийн нэр	Олгосон байгууллага, огноо	Тайлбар
1.				

• Өөрийн болон гэр бүлийн гишүүний эзэмшиж байгаа дараах эрх, патент, ноу-хау, түүнтэй адилтгах бусад эрх, патентын төрөл, эзэмшигчийн нэр, олгосон байгууллагын албан ёсны нэрийг бичнэ.

➤ Зохиогчийн эрх²⁰ болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу эзэмшиж байгаа зохиогчийн эрх;

➤ Патентын тухай хууль²¹, холбогдох бусад хуульд заасан журмын дагуу олж авсан патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, биет бус хөрөнгө буюу оюуны өмчийн эрх;

➤ Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль²²-д заасны дагуу өмчилсөн барааны тэмдэг эзэмших, өмчлөх эрхийг эзэмшиж байгаа төрөөс олгосон баримт бичиг, бүртгэгдсэн барааны тэмдэг, патент;

➤ Технологи дамжуулах тухай хууль²³-д заасны дагуу үйлдвэрлэл, удирдлага, худалдаа, санхүүгийн үнэ цэнэ бүхий бөгөөд хуулиар эрхийн хамгаалалт хийгдээгүй, нууцлагдсан, эзэмшиж ашиглахад тодорхой мэргэшил шаардагдах аливаа мэдлэг, туршлага (ноу-хау)

17 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9243>. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль., 4 дүгээр зүйл, 4.1.7. “үүсмэл санхүүгийн хэрэгсэл /derivativ/” гэж опцион гэрээ, фьючерсийн гэрээ, форвард гэрээ, своп гэрээ болон Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслийг;

18 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9243>. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль., 5 дугаар зүйл.

19 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=128>. Векселийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 1. Вексель” гэж төлбөр хариуцагчаас тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр үл маргалдах журмаар вексель эзэмшигчид төлөхийг харилцан тохиролцож баталсан төлбөрийн баримтыг хэлнэ. Вексель нь төлбөр тооцооны үнэт цаас мөн.

20 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230812154721>

21 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231112526381>

22 <https://legalinfo.mn/mn/detail/111>

23 <https://legalinfo.mn/mn/detail/477>



· **Тайлбар:** дээр дурдсан эрх, патентыг олж авсан хугацааг албан ёсны баримтад бичигдсэнээр, түүнийг олж авахад зарцуулсан хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэрийг дэлгэрэнгүй бичнэ.

· **Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн:** гарын үсэг /гарын үсгийн тайлал/: холбогдох мэдээллийг зааврын дагуу үнэн зөв бичсэнээ илэрхийлж өөрийн нэр, гарын үсгийг зурна.

· **... оны ... дугаар сарын ... -ны өдөр:** мэдүүлэг гаргасан өдрөөр огноог бичнэ.



ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛЭГ (ХАСУМ)-ИЙН ТУХАЙ

ХАСУМ-ийн зорилго?

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ) нь нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ашиг сонирхлын зөрчил үүсэх болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албанд шударга, ил тод байдлыг бэхжүүлэх, олон нийтийн хяналтыг бүрдүүлэхэд дэмжлэг болох зорилготой.

Хэн гаргах вэ?

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заасан албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд ХАСУМ гаргана. Харин сонгогддог албан тушаалтнууд ХАСУМ гаргахгүй.

Хэзээ мэдүүлгээ гаргах вэ?

“Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заасан нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд нь уг албан тушаалд томилогдохын өмнө дээрх тогтоолоор баталсан “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 4.3.1-ийг үндэслэн дараах тохиолдолд ХАСУМ гаргана. Тухайлбал, шинээр, туршилтын хугацаанд, сэлгэн, шилжин, хавсран, хослон, түр орлон гүйцэтгэх гэх мэт.

Харин аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал, хуулийн этгээдийн хэлбэр, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн боловч эрхлэх асуудлын чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт ороогүй, Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажлын байрыг хэвээр хадгалж байсан, шүүхийн шийдвэрээр урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоосон бол дахин ХАСУМ гаргахгүй.

Хэрхэн мэдүүлэх вэ?

ХАСУМ-ийг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем (<https://meduuleg.iaac.mn/>)-д өөрийн эрхээр нэвтрэн орж, ЭБАТ-ны үүсгэсэн мэдүүлгийг үнэн зөв гаргаж, баталгааны маягтад гарын үсэг зурж томилогдохоор нэр дэвшсэн байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

Мэдүүлэг гаргагч нь хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах, тайлбарлах үүрэгтэй.

Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас томилохын өмнө ХАСУМ-ийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт албан бичгийг “Ажлын байрны тодорхойлолт”-ын хамт хүргүүлнэ.



Хариуцлагын тухай?

Мэдүүлэг гаргадаг албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-д “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ” гэж заасны дагуу хянуулаагүй томилсон албан тушаалтанд уг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан хариуцлагыг хүлээлгэдэг.



Авлигатай тэмцэх газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 17-ны
А/96 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

**НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОГДОХООР НЭР ДЭВШСЭН
ЭТГЭЭДИЙН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН
МЭДҮҮЛГИЙН МАЯГТ НӨХӨХ ЗААВАР**

НЭГ. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ, ТҮҮНИЙ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

1.1. Мэдүүлэг гаргагч		
Ургийн овог:	Эцэг/эхийн нэр:	Нэр:
Регистрийн дугаар: 	Нэр дэвшсэн: - Байгууллагын нэр: - Байгууллагын нэгж /газар, хэлтэс, тасаг, алба/-ийн нэр: - Албан тушаалын нэр: - Албан тушаалын ангилал, зэрэглэл:	
Төрсөн газар:		
Оршин суугаа газрын хаяг:		
Цахим шуудангийн хаяг:	Гар утас: үед холбоо барих утас:	Шаардлагатай
Мэдүүлэг гаргах үндэслэл: /дэлгэрэнгүй бичих/		
1.1.1. Та болон таны хамаарал бүхий этгээд нь таны нэр дэвшсэн нийтийн алба (байгууллага), түүний салбар, нэгжийн үйл ажиллагаатай хамааралтай ашгийн төлөө үйл ажиллагааг сүүлийн 2 жилд эрхэлсэн эсэх (Аль тохирохыг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ.) ☐ Тийм бол, тодорхой бичих. ☐ Үгүй		
1.1.2. Та болон таны хамаарал бүхий этгээд оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хуулийн этгээд үүсгэн байгуулсан эсэх (Аль тохирохыг сонгон арын хүснэгтэд ✓ тэмдэглэгээ хийнэ.) ☐ Тийм бол, тодорхой бичих. ☐ Үгүй		

1.1 Мэдүүлэг гаргагч: нийтийн албанд томилогдохоор нэр дэвшиж байгаа этгээдийг ойлгоно. Мэдүүлгийг мэдүүлэг гаргах үеийн байдлаар гаргана.

- **Ургийн овог, Эцэг/эхийн нэр, Нэр:** мэдүүлэг гаргагчийн өөрийн иргэний бүртгэл дээр бүртгэгдсэнээр бичнэ.
- **Регистрийн дугаар:** иргэний улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу мэдүүлэг гаргагч өөрийн иргэний үнэмлэх дээрх бичигдсэн үсэг, тооноос бүтсэн нийлмэл кодыг бичнэ. Хэрэв тухайн мэдүүлэг гаргагч нь гадаад улсын иргэн бол гадаад паспортын дугаар, эсхүл Монгол Улсаас олгосон бүртгэлийн дугаарыг бичнэ.
- **Төрсөн газар:** төрсний гэрчилгээнд бичигдсэн нутаг дэвсгэрийн нэрийг бичнэ.
- **Оршин суугаа газрын хаяг:** иргэний бүртгэлийн хаягийн санд



бүртгэлтэй, улсын бүртгэлд бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хороолол, гудамжны нэр, байрны дугаар, газар, усны нэрийг эсхүл тухайн хаягаас өөр газарт амьдарч байгаа бол тухайн засаг захиргааны нэгжид бүртгүүлсэн байнга оршин сууж байгаа тухайн хаягийг бичнэ.

• **Нэр дэвшсэн:** томилогдохоор нэр дэвшиж байгаа албан тушаалыг харьяалах байгууллага, түүний нэгж (газар, хэлтэс, тасаг, алба), албан тушаал, албан тушаалын ангилал, зэрэглэлийг холбогдох хууль тогтоомж, тушаалд заасан албан ёсны нэршлээр нь тохирох хэсэгт нь бичнэ.

• **Цахим шуудангийн хаяг:** өөрийн тогтмол ашигладаг, идэвхтэй цахим шуудангийн хаяг (и-мэйл)-ийг бичнэ.

• **Гар утас:** өөрийн эзэмшиж байгаа буюу өөрийн нэр дээр бүртгэлтэй үүрэн холбооны дугаарыг бичнэ.

• **Шаардлагатай үед холбоо барих утас:** мэдүүлэг гаргагчтай шууд холбогдох боломжгүй тохиолдолд холбоо баривал зохих хүний нэр, түүний үүрэн холбооны эсхүл ажлын газрын утасны дугаарыг бичнэ.

• **Мэдүүлэг гаргах үндэслэл /дэлгэрэнгүй бичих/:** нийтийн албан тушаалд анх удаа, туршилтын хугацаанд, сэлгэн, төрийн байгууллага, төрийн албан тушаалд шилжин томилогдохоор, ажил, албан тушаал хавсран эсхүл хослон, эзгүй байгаа албан тушаалтны албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн г.м

1.1.1. Та болон таны хамаарал бүхий этгээд нь таны нэр дэвшсэн нийтийн алба (байгууллага), түүний салбар, нэгжийн үйл ажиллагаатай хамааралтай ашгийн төлөө үйл ажиллагааг сүүлийн 2 жилд эрхэлсэн эсэх (Аль тохирохыг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ.):

☐ Тийм бол, тодорхой бичих. ☐ Үгүй

• ☐ **Тийм бол, тодорхой бичих.** гэх сонголтыг хийсэн бол хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг мэдүүлж байгаа хугацаанаас өмнөх буюу сүүлийн 2 жилийн хугацаанд тухайн нийтийн албан тушаалтны хамаарал бүхий этгээд болох эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийн аль нэг нь таны нэр дэвшсэн нийтийн алба (байгууллага), түүний салбар, нэгжийн үйл ажиллагаатай хамааралтайгаар компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг эрхэлсэн бол энэ тухай дэлгэрэнгүй бичнэ.



1.1.2. Та болон таны хамаарал бүхий этгээд оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хуулийн этгээд үүсгэн байгуулсан эсэх (Аль тохирохыг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ.):

☐ Тийм бол, тодорхой бичих. ☐ Үгүй

• ☐ **Тийм бол, тодорхой бичих.** сонголтыг хийсэн бол өөрийн болон хамаарал бүхий этгээд (аль нь болох) -ийн эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан гадаад улс, түүний нутаг дэвсгэр дэх данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан банк, өмчилсөн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн талаарх мэдээллийг албан ёсны нэршлээр нь тодорхой бичнэ.

• Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоол²⁴-ын хавсралтаар “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт”-ыг шинэчлэн баталсан. Үүнд:

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ
ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЗОРИЛГООР ГАРГАСАН ГАДААД УЛС, ТҮҮНИЙ НУТАГ ДЭВСГЭРИЙН ЖАГСААЛТ
(Гарчийг Засгийн газрын 2020 оны 67 дугаар тогтоолоор өөрчилсөн)

	Нэр (монгол хэлээр)	Нэр (англи хэлээр)
1.	Ангиль	Anguilla
2.	Андоррагийн Хант Улс	Andorra
3.	Антигуа Барбуда	Antigua & Barbuda
4.	Арабын Нэгдсэн Эмират	United Arab Emirates
5.	Аруба	Aruba
6.	Барбадос Улс	Barbados
7.	Бахамын арлууд	Bahamas
8.	Бахрейны Хаант Улс	Bahrain
9.	Белиз Улс	Belize
10.	Бермудын арал	Bermuda
11.	Ботсвана	Botswana
12.	Британийн Виржинийн арлууд	British Virgin Islands
13.	Бруней	Brunei
14.	Бүгд Найрамдах Вануату Улс	Vanuatu
15.	Бүгд Найрамдах Кипр Улс	Cyprus
16.	Бүгд Найрамдах Коста-Рика Улс	Costa Rica

24 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208107&showType=1>



17.	Бүгд Найрамдах Либериа Улс	Liberia
18.	Бүгд Найрамдах Ливан Улс	Lebanon
19.	Бүгд Найрамдах Мавритан Улс	Mauritius
20.	Бүгд Найрамдах Мальта Улс	Malta
21.	Бүгд Найрамдах Панам Улс	Panama
22.	Бүгд Найрамдах Уругвай Улс	Uruguay
23.	Гернси	Guernsey
24.	Гибралтар	Gibraltar
25.	Гренад Улс	Grenada
26.	Доминикийн Хамтын Нөхөрлөлийн Улс	Dominica
27.	Жерси	Jersey
28.	Ирланд Улс	Ireland
29.	Кайманы арлууд	Cayman Islands
30.	Куракао	Curacao
31.	Куукийн арлууд	Cook Islands
32.	Лихтенштейний Вант Улс	Liechtenstein
33.	Люксембург	Luxembourg
34.	Макао	Macao, SAR
35.	Малайз	Malaysia
36.	Маршаллын арлууд	Marshall Islands
37.	Монако	Monaco
38.	Монтсеррат Улс	Montserrat
39.	Мэний арал	Isle of Man
40.	Нидерландын Антилийн Арлууд	Netherlands Antilles
41.	Самоагийн Тусгаар улс	Independent State of Samoa
42.	Сейшелийн Арлын Бүгд Найрамдах Улс	Seychelles
43.	Сент-Винсент-Гренадин Улс	St. Vincent and Grenadines
44.	Сент-Китс-Невисийн Холбооны Улс	St. Kitts and Nevis
45.	Сент-Люси Улс	St. Lucia
46.	Сингапур (Засгийн газрын 2024 оны 11 дүгээр тогтоолоор хассан)	Singapore
47.	Тёркс-кайкосын арлууд	Turks and Caicos Islands
48.	Хонконг	Hong Kong, SAR
49.	Швейцар (Засгийн газрын 2024 оны 11 дүгээр тогтоолоор хассан)	Switzerland



1.1.3 Боловсролын талаарх мэдээлэл (Ерөнхий, тусгай дунд, дээд боловсролын, бакалаврын, дипломын, магистрын докторын зэргийг анх суралцсан дарааллаар бичнэ үү.):

1.1.3. Боловсролын талаарх мэдээлэл (Ерөнхий, тусгай дунд, дээд боловсролын, бакалаврын, дипломын, магистр, докторын зэргийг анх суралцсан дарааллаар бичнэ үү.)

№	Сургуулийн нэр	Элссэн он, сар	Төгссөн он, сар	Боловсролын түвшин	Эзэмшсэн мэргэжил	Гэрчилгээ, дипломын дугаар
1.						

Мэдүүлэг гаргагч өөрийн суралцсан сургууль, элссэн, төгссөн огноо, боловсрол, мэргэжлийн нэршлийг түүнийг нотлох албан ёсны баримт (гэрчилгээ, диплом)-д бичигдсэнээр, дарааллуулан бичнэ.

1.1.4 Мэргэшлийн бэлтгэл:

1.1.4. Мэргэшлийн бэлтгэл (Мэргэжлээрээ болон бусад чиглэлээр нарийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байдлыг бичнэ үү.)

№	Хаана, ямар байгууллагад	Эхэлсэн/дууссан он, сар, өдөр	Хугацаа /хоногоор/	Мэргэшлийн чиглэл
1.				

Мэдүүлэг гаргагч өөрийн эзэмшсэн мэргэжлээрээ болон бусад чиглэлээр нарийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байдлыг хаанаас зохион байгуулсан сургалтад ямар чиглэлээр, ямар хугацаанд суралцсан, сургалтын үргэлжилсэн хугацааг албан ёсны баримт (гэрчилгээ, үнэмлэх гэх мэт)-д бичигдсэнээр бичнэ.

1.1.5 Төрийн албаны шалгалтын талаарх мэдээлэл:

1.1.5. Төрийн албаны шалгалтын талаарх мэдээлэл

№	Мэдээллийн агуулга	Шалгалт өгч тэнцсэн огноо	Тусгай шалгалт өгсөн	
			Албан тушаалын нэр	Ангилал зэрэглэл
1.	Ерөнхий шалгалт		х	х
2.	Тусгай шалгалт			
3.	Нөөцөд байгаа эсэх	☐ Тийм бол, тодорхой бичих ☐ Үгүй		

Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн жинхэнэ ерөнхий шалгалт өгч тэнцсэн (нөөцөд бүртгэгдсэн) огноог Төрийн албаны зөвлөлийн тогтоолд зааснаар бичнэ.

Төрийн албаны тухай хуульд зааснаар тухайн албан тушаалын тусгай шалгалт өгч тэнцсэн бол шалгалт өгсөн огноо, албан тушаалын нэр, ангилал, зэрэглэлийг бичнэ.

**1.1.6 Ажил эрхлэлтийн байдал:**

1.1.6. Ажил эрхлэлтийн байдал (анх эрхэлсэн ажил, албан тушаалаас эхлэн бичнэ үү.)					
№	Ажилласан байгууллагын нэр	Газар, хэлтэс, алба	Эрхэлсэн албан тушаал	Ажилд орсон он, сар	Ажлаас гарсан он, сар
1.					

Мэдүүлэг гаргагч өөрийн хөдөлмөр эрхлэлтийн харилцаа эхлүүлснээс хойш одоо томилогдохоор нэр дэвшиж байгаа албан тушаал хүртэл хугацаанд ажиллаж байсан байгууллага, эрхэлж байсан албан тушаалыг албан ёсны, тухайн үеийн нэршлээр нь он цагийн дарааллаар жагсаан бичнэ.

1.1.7 Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал:

1.1.7. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал						
№	Таны юу болох	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар	Эрхэлж буй ажил, албан тушаалын нэр /сурч байгаа бол сургууль, цэцэрлэг г.м./	Оршин суугаа газрын хаяг
1.						

Таны юу болох: мэдүүлэг гаргагчийн эхнэр/нөхөр (гэрлэгчид) тэдэнтэй хамт амьдарч байгаа, оршин суугаа засаг захиргааны нэгжийн өрхийн бүртгэлд бүртгэлтэй хүүхэд (төрсөн, дагавар, үрчлэн авсан, гадаад улсад сурч, ажиллаж байгаа) болон хуульд заасны дагуу гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийн аль нь болохыг бичнэ.

Эцэг/эхийн нэр, нэр, Регистрийн дугаар, Төрсөн газар: тухайн этгээдийн иргэний бүртгэлийн мэдээллийг иргэний үнэмлэхэд бичигдсэнээр бичнэ.

Эрхэлж буй ажил, албан тушаалын нэр/сурч байгаа бол сургууль, цэцэрлэг г.м.: тухайн этгээдийн ажил, албан тушаал, сургууль/цэцэрлэгийн талаарх мэдээллийг албан ёсны нэршлээр нь бичнэ.

Оршин суугаа газрын хаяг: хамт амьдарч байгаа, оршин суугаа засаг захиргааны нэгжийн өрхийн бүртгэлд бүртгэлтэй этгээдийн тухайд энэ хэсэгт ямар нэг бичиглэл хийхгүй. Мэдүүлэг гаргагчийн эхнэр/нөхөр (гэрлэгчид) тэдэнтэй хамт амьдарч байгаа, оршин суугаа засаг захиргааны нэгжийн өрхийн бүртгэлд бүртгэлтэй хүүхэд нь гадаад улсад сурч, ажиллаж байгаа бол түүнийг албан ёсны нэршлээр нь бичнэ.



ХОЁР. ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ: Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг²⁵ ойлгоно.

2.1 Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд:

2.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд						
№	Таны юу болох	Хамаарал бүхий этгээдийн нэр	Төрсөн газар	Ажиллаж байгаа байгууллагын нэр /сурч байгаа бол сургууль/	Эрхэлж байгаа албан тушаалын нэр	Таны нэр дэвшсэн нийтийн алба, байгууллагад ажилладаг, түүний эрхлэх асуудал, харьяалах нутаг дэвсгэрт байгаа эсэх
1.						

• Мэдүүлэг гаргагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр/нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүгийн талаарх мэдээллийг бичнэ.

• Энэ маягт, зааврын “1.1.7 Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал”-д бичсэн гишүүдийн талаарх мэдээллийг давхардуулан бичихгүй.

2.2 Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд:

2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд				
№	Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл	Тайлбар
1.				

• Компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нэр үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч, эцсийн өмчлөгч, ашиг хүртэгч, хуулийн этгээдийн хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг эзэмшиж байгаа аль нь болох, түүнд хамаарах мэдээллийг бичнэ.

• Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн гишүүн нь ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой бөгөөд “Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал” хэсэгт мэдүүлсэн бол энд бичихгүй.

• **Тайлбар:** дээр дурдсанаас гадна шаардлагатай гэж үзэж байгаа мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

²⁵ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль., 3 дугаар зүйл., 3.1.2



2.3 Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл:

2.3. Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл					
№	Төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага, төлөөлөн удирдах зөвлөл зэрэг гишүүнчлэл бүхий байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үүсгэн байгуулагч, дарга, гүйцэтгэх захирал, гишүүний аль нь болох	Элссэн огноо	Тайлбар
1.					

• Энэхүү талбарт дурдсан гишүүнчлэл бүхий байгууллагын талаарх мэдээллийг улсын бүртгэлийн албан ёсны баримтад бичигдсэнээр жагсаан бичнэ.

• **Тайлбар:** дээр дурдсанаас гадна нэмэлт, шаардлагатай гэж үзэж байгаа мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

2.4 Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас:

2.4. Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас						
№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувь нийлүүлсэн/ оруулсан хөрөнгийн хэмжээ (төгрөг), хувь	Хөрөнгө оруулалтын төрөл, тоо	Нэгж хувьцааны анхны үнэ (төгрөг)	Тухайн жилд авсан ногдол ашиг (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.						
	Нийт дүн					

• Өөрийн болон гэр бүлийн гишүүний Монгол Улсад, гадаад улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулсан, хувь нийлүүлсэн хуулийн этгээд (хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани, толгой компани, охин компани, хараат компани, компанийн нэгдэл, салбар, төлөөлөгчийн газар), нөхөрлөл зэрэг ашгийн төлөө хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ, хувьцааны анхны үнийг, төгрөгөөр илэрхийлэгдэх ногдол ашгийн хэмжээг, ийнхүү хөрөнгө оруулсан (худалдан авсан) эх үүсвэрийг мэдүүлэг гаргах үеийн байдлаар тодорхой бичнэ.

• Засгийн газрын болон бусад бонд, үнэт цаас (компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх, хадгаламжийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх (варрант), Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гэж тогтоосон



бусад санхүүгийн хэрэгсэл, үүсмэл санхүүгийн хэрэгсэл (дериватив)²⁶)²⁷, вексель²⁸, хувьчлалын үнэт цаас/тасалбар нь хөрөнгө оруулалтын төрөлд хамаарна.

• **Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн:** гарын үсэг /гарын үсгийн тайлал/: холбогдох мэдээллийг зааврын дагуу үнэн зөв бичсэнээ илэрхийлж өөрийн бүтэн нэр, гарын үсгийг зурна.

• **... оны ... дугаар сарын ... -ны өдөр:** Мэдүүлэг мэдүүлсэн өдрөөр огноог бичнэ.

26 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9243>. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 4 дүгээр зүйл, 4.1.7. "үүсмэл санхүүгийн хэрэгсэл /дериватив/" гэж опцион гэрээ, фьючерсийн гэрээ, форвард гэрээ, своп гэрээ болон Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслийг;

27 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9243>. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 5 дугаар зүйл

28 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=128>. Векселийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 1. Вексель» гэж төлбөр хариуцагчаас тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр үл маргалдах журмаар вексель эзэмшигчид төлөхийг харилцан тохиролцож баталсан төлбөрийн баримтыг хэлнэ. Вексель нь төлбөр тооцооны үнэт цаас мөн.



НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАРЫН ТУХАЙ

Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын зорилго?

Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар нь нийтийн албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, цаашид үүсэж болох аливаа эрсдэлээс хамгаалах, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, нийтийн албанд шударга, ил тод байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг болох зорилготой.

Мэдэгдэл?

“Мэдэгдэл” гэж нийтийн албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ талаар маягтын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргасан мэдээллийг;

Тайлбар?

“Тайлбар” гэж нийтийн албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд энэ талаар маягтын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргасан мэдээллийг;

Ашиг сонирхлын зөрчил?

“Ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал?

“Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг;



Хамаарал бүхий этгээд?

“Хамаарал бүхий этгээд” гэж нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;

Нэгдмэл сонирхолтой этгээд?

“Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;

Хэн гаргах вэ?

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан доорх албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг гаргана. Үүнд:

- Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

- Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

- Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал.

- Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан.

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

- Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

- Эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;

- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн;

Ямар тохиолдолд гаргах вэ?

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан нийтийн албан тушаалтан дараах тохиолдолд ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг гаргана. Үүнд:



- Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

- Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд маягтын дагуу тайлбар гаргана.

- Үнэлгээний хорооны гишүүнээр томилогдохоос өмнө, эсхүл томилогдсон даруйд.

- Үнэлгээний хорооны гишүүн тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл үүссэн, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал илэрсэн бол.

Хэнд гаргах вэ?

Тодорхой албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд мэдэгдэл, тайлбарыг маягтын дагуу шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

Хэрхэн гаргах вэ?

Албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд тухайн албан үүрэг гүйцэтгэхээс татгалзаж мэдэгдэл, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд тайлбарыг маягтын дагуу шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж, шийдвэрлүүлэн өөрийн харьяа байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгч, Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем (<https://meduuleg.iaac.mn/>)-д бүртгүүлнэ.

Хариуцлагын тухай?

Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Нийтийн албан тушаалтан нь ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар гаргах үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, дээрх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг бууруулах болон нийтийн албанаас халах хариуцлагыг хүлээлгэдэг.



Авлигатай тэмцэх газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 17-ны
А/96 дугаар тушаалын гуравдугаар
хэвсрэлт

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАРЫН МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Нэг. Нийтийн албан тушаалтан: Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйл (Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд)-ийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль²⁹-ийн 4 дүгээр зүйл (Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд)-д заасан албан тушаалтанд хамаарна.

Нэг. Нийтийн албан тушаалтан		
Эцэг/эхийн нэр:	Нэр:	Регистрийн дугаар:
Ажиллаж буй байгууллага:.....		Албан тушаал:.....
Мэдэгдэл, тайлбарыг хүлээн авсан байгууллагын нэр:		
Мэдэгдэл, тайлбар гаргаж буй үндэслэл:		

• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

➤ **“нийтийн ашиг сонирхол”** гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг;

➤ **“хувийн ашиг сонирхол”** гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

➤ **“ашиг сонирхлын зөрчил”** гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг.

29 <https://legalinfo.mn/mn/detail/397>



➤ Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

➤ Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

• **Эцэг/эхийн нэр, Нэр:** нийтийн албан тушаалтан өөрийн иргэний бүртгэл дээр бүртгэгдсэнээр бичнэ.

• **Регистрийн дугаар:** иргэний улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу өөрийн иргэний үнэмлэх дээрх бичигдсэн үсэг, тооноос бүтсэн нийлмэл кодыг бичнэ. Хэрэв тухайн нийтийн албан тушаалтан нь гадаад улсын иргэн бол гадаад паспортын дугаар, эсхүл Монгол Улсаас олгосон бүртгэлийн дугаарыг бичнэ.

• **Ажиллаж буй байгууллага, Албан тушаал:** байгууллагын албан ёсны нэрийг товчлохгүй, энэхүү мэдэгдэл, тайлбар гаргаж байгаа үед эрхэлж байгаа албан тушаалын албан ёсны нэрийг бичнэ.

• **Мэдэгдэл, тайлбарыг хүлээн авсан байгууллагын нэр:** мэдэгдэл, тайлбарыг хүлээн авсан тухайн чиг үүргийг гүйцэтгүүлэхээр томилох эрх бүхий, эсхүл шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны болон байгууллагын албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичнэ.

• **Мэдэгдэл, тайлбар гаргаж буй үндэслэл:** нийтийн албан тушаалтан албаны чиг үүргээ хэрэгжүүлэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй эсхүл албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсэн бол дараах үндэслэлээс сонгон тодорхой бичнэ. Үүнд:

- захиргааны шийдвэр гаргах;
- удирдах, хяналт, шалгалт хийх;
- хариуцлага хүлээлгэх;
- гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох;
- тусгайлсан хууль тогтоомжид ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах талаар заасан.



Хоёр: Мэдэгдэл, тайлбарын аль нь болохыг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ үү.

☐ Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй

(Зөвхөн гурав дахь хэсгийн **мэдэгдлийг** гаргах)

☐ Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн (Зөвхөн дөрөв дэх хэсгийн **тайлбарыг** гаргах)

Гурав. Мэдэгдэл: нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд гаргасан мэдэгдлийн талаарх тайлбарыг дэлгэрэнгүй бичнэ.

Гурав. Мэдэгдэл:

Нийтийн албан тушаалтан би дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд өөрийн хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх буюу албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэж, тухайн чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзаж байна.

Мэдэгдэл тодорхой бичих:

Дөрөв. Тайлбар: нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд гаргасан тайлбарыг дэлгэрэнгүй бичнэ.

Дөрөв. Тайлбар:

Нийтийн албан тушаалтан би дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд "ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" буюу өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүнтэй холбоотой зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу тайлбарлаж, тухайн чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзаж байна.

Мэдэгдэл тодорхой бичих:



Тав. Нийтийн албан тушаалтны баталгаажуулалт: ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, тайлбар гаргаж байгаа нийтийн албан тушаалтан “мэдэгдэл”, “тайлбар”-ын аль нь болохыг доогуур нь зурж, өөрийн нэр, албан тушаалын нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал, он, сар, өдрийг бичнэ.

Тав. Нийтийн албан тушаалтны баталгаажуулалт:

_____ би нийтийн албан тушаалтны үүргээ чанд ухамсарлан энэхүү **мэдэгдэл/тайлбарыг** (аль нь болохыг доогуур нь зурах) үнэн зөв гаргасан болохоо үүгээр илэрхийлж баталгаажуулж байна.

..... (.....)

Зургаа. Шийдвэрлэсэн байдал:

Зургаа. Шийдвэрлэсэн байдал

Шийдвэр гаргах удирдах албан тушаалтан /нэр/ _____ би нийтийн албан тушаалтан /нэр/ _____ -ийн/ын/ гаргасан мэдэгдэл, тайлбарт үндэслэн тухайн чиг үүргийг гүйцэтгүүлэхийг зөвшөөрсөн эсэх:

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв “Тийм” бол шалтгааныг сонгон √ тэмдэглэгээг хийнэ үү.

- ☐ тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн чиг үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй;
- ☐ дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;
- ☐ тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа.

Шийдвэр гаргасан удирдах албан тушаалтны баталгаажуулалт:

..... /...../
(Албан тушаал) (Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал) (огноо)

• Мэдэгдэл, тайлбарыг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан тухайн чиг үүргийг гүйцэтгүүлэх эсэхийг зөвшөөрөх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргаж, шийдвэрээ “Тийм”, “Үгүй” гэсэн сонголтын аль нэгийг сонгон зохих тэмдэглэгээг хийнэ.

• “Тийм” гэсэн сонголтыг хийж, байгаа бол маягтад дурдсан үндэслэлээс аль нэгийг сонгон √ тэмдэглэгээг хийнэ.

• **Шийдвэр гаргасан удирдах албан тушаалтны баталгаажуулалт:** тухайн шийдвэр гаргаж буй эрх бүхий албан тушаалтан өөрийн нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал, он, сар, өдрийг бичнэ.



• Ийнхүү баталгаажуулсан шийдвэрийг мэдэгдэл, тайлбар гаргасан нийтийн албан тушаалтанд мэдэгдэж, маягтыг цахим санд бүртгүүлэхээр ЭБАТ-д хүлээлгэн өгнө.

ЭБАТ-аас бөглөх хэсэг: тухайн мэдэгдэл, тайлбарыг шийдвэрлэсэн удирдах албан тушаалтнаас маягтыг хүлээн авч, цахим санд бүртгэх бөгөөд өөрийн (ЭБАТ) эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг, он, сар, өдрийг

ЭБАТ-аас бөглөх хэсэг:

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

(Гарын үсэг)

(Мэдэгдэл/тайлбарыг бүртгэсэн огноо)



ТЭМДЭГЛЭЛ

[illegible]



ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

Мударга ёс, хөгжил дэвшилд



МОНГОЛ УЛС, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

5-р хороолол, Сөүлийн гудамж 41, Улаанбаатар хот 14250



www.iaac.mn



АТГ-Олон нийтийн төв